



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

БИЕЙН ТАМИР

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ASIAN
DEVELOPMENT
BANK



БАГА, СУУР, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

БИЕЙН ТАМИР

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрх зүйн баримт бичгүүд	8
Боловсролын үнэлгээ	18

БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. I АНГИ

1.1. Ахуйн хэрэгцээт дасгал үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	23
1.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	23
1.2. Алхах, гүйх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	24
1.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	25
1.3. Үсрэх, харайх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	25
1.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	26
1.4. Шидэх, дамжуулах үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	26
1.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	26

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2.1. Ахуйн хэрэгцээт дасгал үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	27
2.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	27
2.2. Үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	28
2.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	29
2.3. Үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	29
2.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	29
2.4. Шидэх, дамжуулах үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	30
2.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	30

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3.1. Ахуйн хэрэгцээт дасгал үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	32
3.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	32
3.2. Алхах, гүйх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	34
3.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	34
3.3. Үсрэх, харайх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	35
3.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	35
3.4. Шидэх, дамжуулах үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн.....	36
3.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	36

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4.1. Ахуйн хэрэгцээт дасгал үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	37
4.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	37
4.2. Алхах, гүйх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	39
4.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	39
4.3. Үсрэх, харайх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	40
4.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	40
4.4. Шидэх, дамжуулах үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	41
4.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	41

ТАВДУГААР БҮЛЭГ. V АНГИ

5.1. Ахуйн хэрэгцээт дасгал үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	42
5.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	42
5.2. Алхах, гүйх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	43
5.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	44
5.3. Үсрэх, харайх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	44
5.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	44
5.4. Шидэх, дамжуулах үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	45
5.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	46

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

1.1. VI ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	49
1.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	50
1.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	50
1.2.2. Үнэлгээний нэгж 2. Гимнастик	51
1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик	52
1.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг	54
1.2.5. Үнэлгээний нэгж 5. Хөл бөмбөг	54
1.2.6. Үнэлгээний нэгж 6. Волейбол	55
1.2.7. Үнэлгээний нэгж 7. Үндэсний спорт-хурдан морь	55

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

2.1. VII ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	56
2.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	57
2.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	57
2.2.2. Үнэлгээний нэгж 2. Гимнастик	58
2.2.3. Үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик	58
2.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг	59
2.2.5. Үнэлгээний нэгж 5. Хөл бөмбөг	60
2.2.6. Үнэлгээний нэгж 6. Волейбол	61
2.2.7. Үнэлгээний нэгж 7. Үндэсний спорт-сур харваа	61

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3.1. VIII ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	62
3.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	63
3.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	63
3.2.2. Үнэлгээний нэгж 2. Аэробик	65
3.2.3. Үнэлгээний нэгж 3. Бүжиг	65
3.2.4. Үнэлгээний нэгж 4. Хөнгөн атлетик	66
3.2.5. Үнэлгээний нэгж 5. Сагсан бөмбөг	67
3.2.6. Үнэлгээний нэгж 6. Волейбол	68
3.2.7. Үнэлгээний нэгж 7. Үндэсний спорт-бөхийн барилдаан	68

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IX АНГИ

4.1. IX ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	69
4.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	70
4.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	70
4.2.2. Үнэлгээний нэгж 2. Аэробик	72
4.2.3 Үнэлгээний нэгж 3. Бүжиг	72
4.2.4. Үнэлгээний нэгж 4. Хөнгөн атлетик	73
4.2.5. Үнэлгээний нэгж 5. Сагсан бөмбөг	73
4.2.6. Үнэлгээний нэгж 6. Волейбол	74
4.2.7. Үнэлгээний нэгж 7. Үндэсний спорт-шагайн харваа	75

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. X АНГИ**

1.1. X ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	79
1.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	81
1.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	81
1.2.2. Үнэлгээний нэгж 2. Олон улсын спортын хөгжил	83
1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик	83
1.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг	84
1.2.5. Үнэлгээний нэгж 5. Волейбол	85
1.2.6. Үнэлгээний нэгж 6. Хөл бөмбөг	86
1.2.7. Үнэлгээний нэгж 7. Аэробик	87

ХОЁРДУГААР БҮЛЭГ. XI АНГИ

2.1. XI ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	89
2.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	90
2.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	90
2.2.2. Үнэлгээний нэгж 2. Олон улсын спортын хөгжил	92
2.2.3. Үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик	92
2.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг	93
2.2.5. Үнэлгээний нэгж 5. Волейбол	94
2.2.6. Үнэлгээний нэгж 6. Хөл бөмбөг	94
2.2.7. Үнэлгээний нэгж 7. Аэробик	95

ГУРАВДУГААР БҮЛЭГ. XII АНГИ

3.1. XII ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	96
3.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин	97
3.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил	97
3.2.2. Үнэлгээний нэгж 2. Олон улсын спортын хөгжил	98
3.2.3. Үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик	99
3.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг	99
3.2.5. Үнэлгээний нэгж 5. Волейбол	100
3.2.6. Үнэлгээний нэгж 6. Хөл бөмбөг	101



МЭНДЧИЛГЭЭ

*Эрхэм баян-эрдэм мэдлэгийг түгээн
дэлгэрүүлэгч эрдэмтэн багш нар аа!*

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаарч, боловсролын тогтолцоогоо улам бүр боловсронгуй болгож байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэлд гарч буй ахиц амжилтыг үнэлэхээр үнэлгээний зорилтыг тодорхойлсон бөгөөд суралцагчийн үнэлгээний журамд “үнэлгээ нь шалгуурт суурилсан” байхаар заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулж, баталлаа.

Энэхүү шалгуур үзүүлэлт батлагдсанаар суралцагчийн ахиц амжилтыг ижил шалгуураар үнэлэх /суралцагчдын ялгаатай байдлыг тодорхойлох/, хичээлийн бэлтгэлийг чанартай хангах /ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, ээлжит хичээлийн төлөвлөлт хийх/ зэрэг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах, эргэх холбоотой ажиллах боломж бүрдэх юм.

Оюунлаг, чадварлаг, бүтээлч шинэ эриний “Монгол хүн” бүтээх гол цөм, тулах цэг нь болсон багш, боловсролын ажилтан та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон эрдэмтэн багш, судлаач нар болон техникийн дэмжлэг үзүүлсэн Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны “Бага боловсролын шинэчлэл” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайд



МЭНДЧИЛГЭЭ

Боловсролын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа эрдэмтэн багш, боловсролын ажилтан, судлаачид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Суралцагчдад хаана, ямар орчинд суралцаж байгаагаас үл хамааран ижил шалгуур, ижил арга, аргачлалаар сурлагын амжилт, ахицаа бодитой тодорхойлуулах хэрэгцээ ямагт байдаг. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг бодитой, шинжлэх ухаанчаар үнэлж дүгнэн үнэлгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд үр нөлөөтэйгээр хэрэглэх нь манай орны төдийгүй дэлхийн улс орнуудын багш нарт ч сорилт хэвээр байна.

2018 онд БСШУС-ын (хуучнаар) сайдын А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээг шалгуурт суурилсан бөгөөд суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын ахиц, амжилтыг дэмжиж, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлсон нь дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээний шалгуур нь хичээл, сургалтын үр дүнд суралцагчийн юу мэддэг, юу чаддаг, яаж хийж хэрэглэх ёстойг тодорхойлж өгсөн суралцахуй, багшлахуйн ач холбогдолтой “үнэлгээний гол хэрэгсэл” юм. Багш та үнэлгээний шалгуурыг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэснээр суралцагчийн гүйцэтгэлд тулгуурлан сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийн талаар бодитой, үр нөлөөтэй үнэлэлт, дүгнэлт хийж тэдэнд ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэхээ тодорхойлох бүрэн боломж бүрдэнэ.

Боловсролын үнэлгээний төв нь хичээл тус бүрээр эрдэмтэн, багш, судлаачдын баг бүрдүүлэн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр үнэлгээний ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖИЙН түвшинд анх удаагаа боловсруулж та бүхний гар дээр хүргэж байна.

Үнэлгээний шалгуурыг олон улсын түвшинд боловсролын үнэлгээ, тэр дундаа суралцагчийн үнэлгээ, үнэлгээний шалгуур чиглэлээр баримталж буй онол, үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуйн онцлогийг харгалзан боловсруулсан.

Боловсролын үнэлгээний тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах эрхэм багш та бүхний үйлс нь улам өөдөө байж, боловсролын хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэл нэгдэн урагшилна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Лхагвасүрэнгийн **ГАНБАТ**
Захирал

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ТУШААЛ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 07 сарын 23-ны
өдрийн 3967 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам, загвар шинэчлэн батлах тухай” А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

0001553

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
А/425 дугаар тушаалын хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт /цаашид "улсын шалгалт" гэх/ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

Түвшин	Үнэлгээ, хувиар	Үнэлгээний түвшний шалгуур
VIII	90-100	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг
VII	80-89	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг
VI	70-79	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг - Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг
V	60-69	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг
IV	50-59	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон. - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг - Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог. - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

III	40-49	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг - Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг - Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг
II	30-39	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цээжлэх түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг
I	0-29	Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшилийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл
Бага боловсрол	III	1	Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/
	IV	2	- Сургууль сонгох 1 хичээл - Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/
Суурь боловсрол	VI	2	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл
	VII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
	VIII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
Бүрэн дунд боловсрол	X	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/
	XI	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон “Анги дэвших шалгалтын блюпринт” /цаашид блюпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон “Шалгалтын комисс” зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага боловсрол	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль
Суурь Боловсрол	IX	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./ • Байгалийн ухааны нэгдмэл агуулга • Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 4. Гадаад хэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

5.7.Боловсролын үнэлгээний бэйгууллага нь "Улсын шалгалтын блопринт" /цөмшд блопринт" гэдг, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15- ны өдрийн дотор баталгаажуулах, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн бэйгууллагад хүргүүлнэ.

5.8.Боловсролын үнэлгээний бэйгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хэлтсбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" /цөмшд "даалгаврын сан" гэдг бүрдүүлэх, шинэчлэх, бэхжүүлэлт хийх ажлыг хариуцна.

5.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн бэйгууллага нь "Улсын шалгалтын комисс"- ыг жил бүрийн 5 дугаар сарын 01 –ний өдрийн дотор бэйгуулна. Энэхүү комисс нь тусгай орон нутагт улсын шалгалт зохион бэйгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль даар улсын шалгалт зохион бэйгуулахтай холбогдуулан энэхүү журын 4.6-д зассан шалгалтын комисс даргах чиг үүрмийг хэрэгжүүлнэ.

5.10.1.улсын шалгалтын удирдах, дэнийг боловсруулах, шалгалтыг зохион бэйгуулах;

5.10.2.шалгалт эхнээс 1 өдрийн өмнө энэхүү журын 5.7-д зассан блопринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулах, нууцлалыг хариуцах;

5.10.3.шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион бэйгуулах, хяналт тавих;

5.10.4.хөгжлийн баримттай суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн өвчлөг, хэрэгцэнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5.улсын шалгалттай холбогдон гарсан өмнө мэдвэныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6.шалгалтын материал, тайланг сургуулийн өрхөт хүлээлгэн өгөх.

5.11.Шалгалт зохион бэйгуулах хуваанд улсын болон олон улсын уралдан, тэмцэнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тохино.

5.12.Суралцагч өмнөх, өр гарийн гэмдэл тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тохино.

5.13.Боловсролын үнэлгээний бэйгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинэчлээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв бэйгууллага болон боловсролын эрдэм шинэчлээ, арга зүйн бэйгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14.Журын 5.9-д зассан "Улсын шалгалтын комисс" нь улсын шалгалт зохион бэйгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв бэйгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион бэйгуулалт

6.1.Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлалын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2.Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний бэйгууллага зохион бэйгуулна.

6.3.Чанарын үнэлгээнд өмнө бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-нас доошгүй хувийг хамруулна.

6.4.Боловсролын үнэлгээний бэйгууллага нь чанарын үнэлгээ зохион бэйгуулах төвөг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв бэйгууллагын саналыг үндэслэн тогтохно.

6.5.Чанарын үнэлгээг зохион бэйгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний бэйгууллага, боловсролын эрдэм шинэчлгээ, арга зүйн бэйгууллага хамтран жил бүрийн 01 дугаар сард багтан тогтохно.

6.6.Боловсролын үнэлгээний бэйгууллага нь чанарын үнэлгээг зохион бэйгуулах удирдах, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулах, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны бэйгууллагаар баталгаажуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

В.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, бөгшөөн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

В.8.Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын В.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, авчиган туслах ажлыг зохион байгуулна.

В.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сургалын ажиллыг сайжруулах төлөвлөгөө гаргах ажиллана.

В.10.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгууллагад бүх талаар дэмжлэг үзүүлэх ажиллана.

Далха. Бусад

7.1.Аливаа төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглогно.

—сОп—

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН А/180 ТУШААЛ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/425 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хавсралтаар баталсугай.

2. Суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг энэхүү тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур"-ыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үнэлсүгэй.

3. Шалгуурын дагуу үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатарт даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110643

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ
(*Student assessment*)

Сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц;

ШАЛГУУР
(*Criteria*)

Зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин;
(UNESCO-CEPES, 2007)

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
(*Assessment criteria*)

Суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.

ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ
(*Diagnostic assessment*)

Хичээл, сургалтын эхэнд суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг тандах зорилгоор хийгдэх үнэлгээ;

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ
(*Formative assessment*)

Багш, суралцагчийн зүгээс суралцагчийн “суралцахуй”-г танин мэдэх, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор сургалтын явц /ээлжит хичээл/-д хийгдэх үнэлгээ;

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ
(*Summative assessment*)

Хичээл, сургалт /нэгж, хагас жил, жилийн эцэст г.м тодорхой хугацааны/-ын дараа үнэлгээний шалгуурт хүрсэн байдлыг тогтоож, цаашид суралцахуй болон багшлахуйд анхаарах зүйлийг тодорхойлох зорилгоор хийгдэх үнэлгээ;

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшилийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:

- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох


ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс" судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР



БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

БИЕИЙН ТАМИР

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - I анги
Хоёрдугаар бүлэг - II анги
Гуравдугаар бүлэг - III анги
Дөрөвдүгээр бүлэг - IV анги
Тавдугаар бүлэг - V анги

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. I АНГИ

1.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилтын код, өгүүлбэр	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	1.1а. Хувцасны эрүүл ахуйн шаардлагыг биеийн тамирын хичээлд хувцасаа өмсөх, хадгалахдаа хэрэгжүүлэх	Ахуйн хэрэгцээт дасгал	- Сурагч биеийн өндөр, жингээ хэмжиж тодорхойлно.
	1.1б. Багшийн үгэн заавраар өндрөөсөө намхан руу нэг эгнээ, хоёроор тоолон нэг эгнээнээс хоёр эгнээ жагсаж харуулах, хөлөө зөөж баруун, зүүн тийш эргэлтийг гүйцэтгэх		- Сурагч гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэн, эдгээрээс бүрдсэн өглөөний цогц дасгалыг хийж харуулна.
	1.1в. Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэх, танин ялгах, үндсэн хөдөлгөөн бүхий цогц дасгалыг хөгжмийн аянд зөв гүйцэтгэх, том бөмбөгтэй цогц дасгалыг хийж харуулах		- Сурагч хүч, хөдөлгөөний эвсэл, уян хатны дасгалыг гүйцэтгэж, эдгээр чадавхын хөгжлөө харуулна.
	1.1г. Багшийн тусламжтайгаар өөрийн биеийн өндөр, жинг хэмжиж тодорхойлох, биеийн зөв галбиртай болох дасгалыг гүйцэтгэх		
	1.1д. Өглөөний цогц дасгалыг дарааллын дагуу тогтмол хийж хэрэгжүүлэх		
	1.1е. Янз бүрээр мөлхөх аргыг ашиглах, ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнөөр авирах аргыг гимнастикийн хана, налуу байрлуулсан гимнастикийн сандал өөд авирахдаа хэрэглэх		
	1.1ж. Өөрийн биеийн жинг ашиглан гараа ардаа тулж суусан байдлаас, гимнастикийн сандал дээр, 50-60 см өндөр тавцан дээр тулалтаас хүчний дасгалыг тодорхой тоогоор гүйцэтгэх		
	1.1з. Сунгалтын ба савалтын идэвхтэй дасгалаар уян чадавхаа сайжруулан, зогсоо байдлаас өвдөг нугалахгүй бөхийж гарын хурууны үзүүрийг газарт хүргэж харуулах		
	1.1и. Янз бүрийн байдлаас шагайг дунд ба долоовор хуруугаар няслаж тоглохдоо талуудыг нэрлэх, дөрвөн бэрхийг үзүүлж тайлбарлах		

1.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
2	Сурагч биеийн өндөр, жингээ хэмжиж тодорхойлно.	Биеийн өндөр, жингээ багшийн тусламжтай хэмжин, өөрийн үзүүлэлтийг хэлж чаддаг.
3	Сурагч гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэн, эдгээрээс бүрдсэн өглөөний цогц дасгалыг хийж харуулна.	Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэж, өглөөний цогц дасгалыг гүйцэтгэдэг.
4	Сурагч хүч, хөдөлгөөний эвсэл, уян хатны дасгалыг гүйцэтгэж, эдгээр чадавхын хөгжлөө харуулна.	Гимнастикийн хананд авирч, буухдаа ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнийг ашигладаг.
		Гарын тулалтаас хүчний дасгалыг зохих тоогоор гүйцэтгэдэг.
		Сунгалтын идэвхтэй аргыг ашиглан уян хатны дасгалыг гүйцэтгэдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Биеийн өндөр, жингээ багшийн тусламжтай хэмжин, өөрийн үзүүлэлтийг хэлж чаддаг.	Биеийн өндөр жингээ хэлж чадаагүй.	Биеийн өндөр жингийнхээ аль нэгийг нь хэлж чаддаг.	Биеийн өндөр, жингээ хоёуланг нь хэлж чаддаг.
Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг нэрлэж, өглөөний цогц дасгалыг гүйцэтгэдэг.	Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг огт нэрлээгүй, өглөөний цогц дасгалыг бусдыг даган дуурайж гүйцэтгэдэг.	Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг гүйцэт биш нэрлэж, өглөөний цогц дасгалыг бие даан хийсэн боловч 1-2 алдаатай гүйцэтгэдэг.	Гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг гүйцэт нэрлэж, өглөөний цогц дасгалыг бие даан зөв гүйцэтгэдэг.
Гимнастикийн хананд авирч, буухдаа ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнийг ашигладаг.	Гимнастикийн хана руу авирч, буухдаа ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнийг буруу гүйцэтгэдэг.	Гимнастикийн хана руу авирч, буухдаа ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнийг зөв боловч хурдтай бус гүйцэтгэдэг.	Гимнастикийн хана руу авирч, буухдаа ижил нэрийн ба эсрэг нэрийн хөдөлгөөнийг зөв, чөлөөтэй, хурдтай гүйцэтгэдэг.
Гарын тулалтаас хүчний дасгалыг зохих тоогоор гүйцэтгэдэг.	Гарын тулалтаас хүчний дасгалыг тогтоосон дунджаас бага хугацаанд гүйцэтгэдэг.	Гарын тулалтаас хүчний дасгалыг тогтоосон дундаж хугацаанд гүйцэтгэдэг.	Гарын тулалтаас хүчний дасгалыг тогтоосон дээд хугацаанд гүйцэтгэдэг.
Сунгалтын идэвхтэй аргыг ашиглан уян хатны дасгалыг гүйцэтгэдэг.	Сунгалтын дасгалыг бага далайцтай гүйцэтгэдэг.	Сунгалтын дасгалыг дунд зэргийн далайцтай гүйцэтгэдэг.	Сунгалтын дасгалыг хамгийн дээд далайцтай гүйцэтгэдэг.

1.2. АЛХАХ, ГҮЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
2	1.2а. Биеийн ба гар, хөлийн зөв хосолсон хөдөлгөөнийг алхах, гүйхдээ хэрэглэх, хурдан гүйх хэрэгцээг тодруулах 1.2б. Жижиг саадыг давж алхах, 10 см нарийн зурвас дээгүүр болон 20-30 см өндөр гимнастикийн сандал дээгүүр алхахдаа хөдөлгөөнөө зөв зохицуулж харуулах 1.2в. Хөлөө хагас нугалан, өлмий, өсгий дээр урагш ба арагш, хавсарч, том, жижиг, өвдөг өндөр өргөж, хөлөө солибож, биеийн зөв галбираа хадгалан, гарын хөдөлгөөнтэй алхаж харуулах 1.2г. Биеийн зөв галбираа хадгалан, гарын 4 янзын хөдөлгөөнтэй алхаж харуулах 1.2д. Шулуун замд 10-15 м зайд дунд зэргийн хурдтай гүйх дасгал, тоглоомыг бүтээлчээр гүйцэтгэх 1.2е. Гадаа талбайд 300 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах	Алхах, гүйх	- Сурагч жижиг саад дээгүүр даван, нарийн зурвасаар гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхаж харуулна.
			- Сурагч алхаа, гүйлтийг хослуулан 300 м зайг туулж харуулна.

1.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч жижиг саад дээгүүр даван, нарийн зурвасаар гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхаж харуулна.	Нарийн зурвас дээрх саадуудыг даван, гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхдаг.
2	Сурагч алхаа, гүйлтийг хослуулан 300 м зайг туулж харуулна.	Алхах, гүйхийг хослуулан 300 м зайг туулдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Нарийн зурвас дээрх саадуудыг даван, гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан зарим саадыг даван, гарын 2-оос цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаас нэлээд хазайн алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан ихэнх саадыг даван, гарын 3-аас цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаар бага зэрэг хазайн алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан бүх саадыг даван, гарын 4-өөс цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаас хазайлгүй алхдаг.
Алхах, гүйхийг хослуулан 300 м зайг туулдаг.	Ихэнх зайд алхаж, багахан зайд гүйж 300 м замыг туулдаг.	Нийт зайн хагасыг нь гүйж, хагасыг нь алхаж, 300 м замыг туулдаг.	Ихэнх зайд гүйж, үлдсэнийг нь алхаж, 300 м замыг туулдаг.

1.3. ҮСРЭХ, ХАРАЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
3	1.3а. Харайхдаа хөлөө бага зэрэг нугалсан байдлаас хүчтэй түлхэх, гараа савах, зөөлөн газардах үйлдлүүдийг уялдуулах учрыг олох 1.3б. Байрандаа дээсэнд хоёр хөл дээр үсэрч тоглохдоо дээсийг бугуй, тохойн үеэр эргүүлэх аргыг ашиглах 1.3в. Үсэрч тоглохдоо нэг ба хоёр хөл дээрээ янз бүрийн чиглэл рүү үсрэх, эргэх аргыг ашиглах 1.3г. Байрнаас хоёр хөлөөр түлхэн урагш, хажуу тийш үсэрч, 15-20 см өндөрт татсан резин дээгүүр давж, 20 см өндөр тавцан дээр гарч, 70-80 см хол харайж харуулах 1.3д. Алхалт, гүйлтээс нэг хөлөөр түлхэн үсэрч, хоёр хөл дээр зөөлөн бууж үзүүлэх 1.3е. Хоёр хөлөөр түлхэн үсэрч, цувруулан тавьсан 6-8 ш саадыг давж харуулах	Үсрэх, харайх	- Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийн үйлдлийг уялдуулан байрнаас янз бүрийн чиглэлд үсэрч харуулна.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

1.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийн үйлдлийг уялдуулан байрнаас янз бүрийн чиглэлд үсэрч харуулна.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас янз бүрийн чиглэлд зөв үсэрдэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас янз бүрийн чиглэлд зөв үсэрдэг.	Гарын савалт, хоёр хөлийн түлхэлтийг зөрүүлж, бүх чиглэл рүү үсрэхдээ тэнцвэрээ бага зэрэг алдан хоёр хөл дээр буудаг.	Гарын савалт, хоёр хөлийн түлхэлтийг уялдуулан, бүх чиглэл рүү үсэрч тэнцвэрээ бага зэрэг алдсан боловч хоёр хөл дээр буудаг.	Гарын савалт, хоёр хөлийн түлхэлтийг уялдуулан, бүх чиглэл рүү зөв үсэрч, тэнцвэрээ хадгалан хоёр хөл дээр буудаг.

1.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
4	1.4а. Бөмбөгний жин, хэмжээг таних, шидэлтийн үеийн аюулгүй байдлын дүрмийг тайлбарлах	Шидэх, дамжуулах	- Сурагч дунд зэргийн бөмбөгийг оновчтой өнхрүүлж үзүүлнэ.
	1.4б. Дунд зэргийн хэмжээтэй бөмбөгөөр тоглохдоо бөмбөгийг 1 м зайнаас нэг ба хоёр гараар дамжуулах, барьж авах, өнхрүүлж оновчтой дамжуулах аргыг ашиглах		- Сурагч том бөмбөгийг байрнаас аль болох хол шидэж харуулна.
	1.4в. Байрнаасаа жижиг бөмбөгийг шидэн байг онох ба 1-2 м өндөрт татсан уяа хэцийг давуулж харуулах		
	1.4г. Том бөмбөгийг байрнаасаа хоёр гараар, жижиг бөмбөгийг нэг гараар аль болох хол шидэж харуулах		

1.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч дунд зэргийн бөмбөгийг оновчтой өнхрүүлж үзүүлнэ.	Дунд зэргийн бөмбөгийг нэг гараар өнхрүүлж 2-4 м зайнд байрлах байг онодог.
2	Сурагч байрнаасаа том бөмбөгийг аль болох хол шидэж харуулна.	Том бөмбөг шидэх аргыг ашиглан байрнаас хоёр гараар хол шиддэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Дунд зэргийн бөмбөгийг нэг гараар өнхрүүлж байг онодог.	Дунд зэргийн бөмбөгийг нэг гараар өнхрүүлж бага зайнд байрлах байг онодог.	Дунд зэргийн бөмбөгийг нэг гараар өнхрүүлж дундаж зайнд байрлах байг онодог.	Дунд зэргийн бөмбөгийг нэг гараар өнхрүүлж хол зайнд байрлах байг онодог.
Том бөмбөг шидэх аргыг ашиглан байрнаас хоёр гараар бөмбөгийг хол шиддэг.	Том бөмбөг шидэх аргыг ашиглан байрнаас хоёр гараар бөмбөгийг бага зайд шиддэг.	Том бөмбөг шидэх аргыг ашиглан байрнаас хоёр гараар бөмбөгийг дундаж зайд шиддэг.	Том бөмбөг шидэх аргыг ашиглан байрнаас хоёр гараар бөмбөгийг хол зайд шиддэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	2.1а. Эрүүл байхын тулд биеийн тамирын олон төрлийн дасгалыг сурч, тогтмол хийх хэрэгтэйг өөрийн үгээр тайлбарлах	Ахуйн хэрэгцээт дасгал	- Сурагч өөрийн биеийн өндөр, жинд үндэслэн биеийн өсөлтөө тодорхойлно.
	2.1б. Багшийн командаар нэг эгнээ ба нэг эгнээнээс хоёр эгнээ жагсах, дэс дараагаар тоолох, баруун, зүүн тийш эргэлтийг гүйцэтгэх		- Сурагч гар хөлийн завсрын хөдөлгөөнийг нэрлэж, цацагтай цогц дасгалыг гүйцэтгэнэ.
	2.1в. Өглөөний дасгалыг тогтмол гүйцэтгэх, өөрийн биеийн өндөр ба жингийн өсөлтийг хэмжиж тодорхойлох		- Сурагч хүч, хөдөлгөөний эвсэл, уян хатны дасгалыг гүйцэтгэж, эдгээр чадавхын хөгжлөө харуулна.
	2.1г. Гар, хөл, их биеийн завсрын хөдөлгөөнийг хослуулан цаасан саваатай, цацагтай, зөөлөн бөмбөгтэй цогц дасгалыг гүйцэтгэх		
	2.1д. Гимнастикийн хананд дүүжигнэлтээс хөлөө нугалан өргөж буулгах, биеэ баруун, зүүн тал руу ээлжлэн эргүүлэх, хөлөө савах, хажуу тийш шилжилтийг гүйцэтгэх		
	2.1е. Тулж суултаас урагш ба арагш өнхрөх, урагш хоёр өнхрөөд босож зогсон харуулах		
	2.1ж. Янз бүрийн тулалтаас сунаих, зэрэгцүүлж тавьсан гимнастикийн сандал дээр тулалтаас урагш, арагш шилжих, ардаа тулж суусан байдлаас хөлөө шулуун өргөж 10 сек өнцөг барихдаа бие биенээ хүндэлж, бусаддаа саад болохгүйгээр хамтран гүйцэтгэх		
	2.1з. Хэрэгсэлтэй ба хэрэгсэлгүй дасгалаар уян хатны чадавхаа хөгжүүлэх		
	2.1и. Янз бүрийн байрлалаас шагайг няслан 40-60 см зайд буй шагайг онож уян хатан, хөдөлгөөний эвслээ сайжруулах, шагай няслах, морь уралдуулах, шагай таалцан тоглохдоо шударгаар өрсөлдөн тоглоомын дүрмийг хэрэгжүүлэх		

2.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өөрийн биеийн өндөр, жинд үндэслэн биеийн өсөлтөө тодорхойлно.	Өөрийн биеийн жин, өндрийн өсөлтөө багшийн тусламжтай хэмжин өсөлтийг хэлдэг.
2	Сурагч гар хөлийн завсрын хөдөлгөөнийг нэрлэж, цацагтай цогц дасгалыг гүйцэтгэнэ.	Гар, хөлийн завсрын хөдөлгөөнийг нэрлэж, үндсэн хөдөлгөөнтэй хослуулсан цацагтай 32 тоот цогц дасгалыг гүйцэтгэдэг.
3	Сурагч хүч, хөдөлгөөний эвсэл, уян хатны дасгалыг гүйцэтгэж, эдгээр чадавхын хөгжлөө харуулна.	Гарын тулалтаас хүчний дасгалыг зохих тоогоор гүйцэтгэдэг.
		Сунгалтын идэвхтэй аргыг ашиглан уян хатны дасгалыг гүйцэтгэдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Өөрийн биеийн жин, өндрийн өсөлтөө багшийн тусламжтай хэмжин өсөлтийг хэлдэг.	Биеийн жин, өндрийн өсөлтийнхөө аль нэгийг хэлдэг.	Биеийн жин, өндрийн хэмжээг хоёуланг нь хэлдэг.	Биеийн жин, өсөлтийн өөрчлөлтөө тооцоолж хэлдэг.
Гар, хөлийн завсрын хөдөлгөөнийг нэрлэж, үндсэн хөдөлгөөнтэй хослуулсан цацагтай 32 тоот цогц дасгалыг зөв гүйцэтгэдэг.	Гар, хөлийн завсрын хөдөлгөөнийг огт нэрлээгүй, цацагтай 32 тоот цогц дасгалыг бусдын дэмжлэгтэй гүйцэтгэдэг.	Гар, хөлийн завсрын хөдөлгөөнийг гүйцэт биш нэрлэж, цацагтай 32 тоот цогц дасгалыг бие даан хийсэн боловч 1-2 алдаатай гүйцэтгэдэг.	Гар, хөлийн завсрын хөдөлгөөнийг гүйцэт нэрлэж, цацагтай 32 тоот цогц дасгалыг бие даан зөв гүйцэтгэдэг.
Гарын тулалтаас хүчний дасгалыг зохих тоогоор гүйцэтгэдэг.	Гарын тулалтаас хүчний дасгалыг тогтоосон дунджаас бага хугацаанд гүйцэтгэдэг.	Гарын тулалтаас хүчний дасгалыг тогтоосон дундаж хугацаанд гүйцэтгэдэг.	Гарын тулалтаас хүчний дасгалыг тогтоосон дээд хугацаанд гүйцэтгэдэг.
Сунгалтын идэвхтэй аргыг ашиглан уян хатны дасгалыг гүйцэтгэдэг.	Сунгалтын дасгалыг бага далайцтай гүйцэтгэдэг.	Сунгалтын дасгалыг дунд зэргийн далайцтай гүйцэтгэдэг.	Сунгалтын дасгалыг хамгийн дээд далайцтай гүйцэтгэдэг.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
2	2.2а. Жагсаалын алхаа, энгийн алхааны ялгааг таних, ангиараа жагсаж алхах шаардлагыг биелүүлэх 2.2б. Гараа нугалан урагш-хойш савж, 200-300 м зайд хурдтай алхаж харуулах 2.2в. Чиглэлээ өөрчлөн хэрж ба тэмдэгтийг сүлжин алхах, гүйх, хөлөө солибон хажуугаараа хурдтай алхах, байрандаа өвдөг өндөр өргөн гүйж харуулах 2.2г. Мэдэгдэж буй дохиогоор гараанаас гарч, шулуун замд 20 м зайд дээд хурдаар, 20-25 м зайд 2-3 удаа давтан гүйж харуулах 2.2д. Гимнастикийн сандал дээгүүр гүйх, бөмбөг, урт сандал зэрэг саадыг давах, 15 см өргөн зурвас дундуур хурдтай гүйх зэргээр гүйхдээ өөрийн хөдөлгөөнөө удирдан, хүчээ оновчтой хуваарилах 2.2е. 400 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах	Алхах, Гүйх	- Сурагч гараанаас 20 м зайд дээд хурдаар гүйх ба алхаа, гүйлтийг хослуулан 400 м зайг туулж харуулна.

2.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гараанаас 20 м зайд дээд хурдаар гүйх ба алхаа, гүйлтийг хослуулан 400 м зайг туулж харуулна.	Босоо гараанаас 20 м зайд өөрийн дээд хурдаар гүйдэг.
		Алхах, гүйхийг хослуулан 400 м зайг туулдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Гараанаас 20 м зайд өөрийн дээд хурдаар гүйдэг.	20 м зайд бага хурдтай гүйдэг.	20 м зайд дунд зэргийн хурдтай гүйдэг.	20 м зайд дээд хурдаар гүйдэг.
Алхах, гүйхийг хослуулан 300 м зайг туулдаг.	Ихэнх зайд алхаж, багахан зайд гүйж 300 м замыг туулдаг.	Нийт зайн хагасыг нь гүйж, хагасыг нь алхаж, 300 м замыг туулдаг.	Ихэнх зайд гүйж, үлдсэнийг нь алхаж, 300 м замыг туулдаг.

2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
3	2.3а. Резин давж үсрэх ба дээсдэж тоглохдоо байрандаа нэг хөл дээр үсрэх чадвар болон тоглоомын дүрмийг ашиглах, хөлийн хүч болон хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх 2.3б. Гүйлтээс хол харайх аргыг хэрэгжүүлэн, 6-8 м зайнаас гүйж, нэг хөлөөр түлхэн уртад 1.5-2 м-ээс хол харайж үзүүлэх 2.3в. Гүйлтээс үсэрч 150-180 см өндөрт дүүжилсэн зүйлд нэг гараар хүрэх ба 30-40 см өндөр тавцан дээр хоёр хөлөөр үсэрч гараад, үсрэн бууж харуулах 2.3г. Нэг ба хоёр хөл дээрээ урагш, хажуу тийш, арагш үсэрч явах, түлхэлт савалт хосолсон дасгалыг ашиглан хөлийн хүч ба уян хатныг хөгжүүлэх 2.3д. Байрнаас уртад 80-95 см-ээс хол харайж харуулах	Үсрэх, Харайх	- Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас ба гүйлтээс уртад аль болох хол харайж харуулна.

2.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас ба гүйлтээс уртад аль болох хол харайж харуулна.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас уртад аль болох хол харайдаг.
		Гүйлтээс хол харайх аргыг хэрэгжүүлэн, 6-8 м зайнаас гүйж нэг хөлөөр түлхэн, уртад аль болох хол харайж үзүүлдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас уртад аль болох хол харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг хослуулан, байрнаас уртад харайхдаа энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс доогуур харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг хослуулан, байрнаас уртад харайхдаа энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээр харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг зөв хослуулан, байрнаас уртад харайхдаа энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс нэлээд илүү харайдаг.
Гүйлтээс хол харайх аргыг хэрэгжүүлэн, 6-8 м зайнаас гүйж, нэг хөлөөр түлхэн, уртад аль болох хол харайж үзүүлдэг.	Бага хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэж агаарт бага зэрэг нисэлт үзүүлээд, хоёр хөлөө зэрэгцүүлэлгүй бууж үзүүлдэг.	Дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэж, агаарт бага зэрэг нисэлт үзүүлээд, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж, хол харайж үзүүлдэг.	Нэлээд хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэж, агаарт нисэлтийг тод харагдахуйц үзүүлээд, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж, аль болох хол харайж үзүүлдэг.

2.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
4	2.4а. Нэг ба хоёр гараар жижиг бөмбөгийг шидэж, өнхрүүлэн 2-3 м зайд буй байг онож харуулах, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх	Шидэх, Дасмжуулах	- Сурагч жижиг бөмбөгийг өнхрүүлэн, байг онож хөдөлгөөний эвслээ харуулна.
	2.4б. Дунд зэргийн бөмбөгийг байрандаа нэг гараар залалтыг гүйцэтгэх		
	2.4в. Дунд зэргийн бөмбөгийг 2 м зайнаас дамжуулахдаа нэг ба хоёр гараар оновчтой дамжуулах аргыг ашиглах		- Сурагч бөмбөгийг хол шидэх аргыг ашиглан байрнаасаа жижиг бөмбөгийг хол шидэж харуулна.
	2.4г. 100-150 гр жинтэй жижиг бөмбөгийг байрнаасаа нэг гараар хол шидэж харуулах		
	2.4д. Гарын хүч, шидэх чадвараа хөгжүүлэхдээ байрнаасаа, янз бүрийн байдлаас бөмбөгийг хол шидэх аргыг ашиглах		

2.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч жижиг бөмбөгийг өнхрүүлэн байг онож, хөдөлгөөний эвслээ харуулна.	Жижиг бөмбөг 2-3 м зайнаас өнхрүүлж, газарт байрлуулсан байг онодог.
2	Сурагч бөмбөгийг хол шидэх аргыг ашиглан байрнаасаа жижиг бөмбөгийг хол шидэж харуулна.	Байрнаасаа нэг гараар жижиг бөмбөгийг хол шидэж харуулдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин		
	I	II	III
Жижиг бөмбөг 2-3 м зайнаас өнхрүүлж, газарт байрлуулсан байг онодог.	Тогтоосон бага зайд байрлуулсан байг жижиг бөмбөг өнхрүүлж онодог.	Тогтоосон дундаж зайд байрлуулсан байг жижиг бөмбөг өнхрүүлж онодог.	Тогтоосон хол зайд байрлуулсан байг жижиг бөмбөг өнхрүүлж онодог.
Байрнаасаа нэг гараар жижиг бөмбөгийг хол шидэж харуулдаг.	Жижиг бөмбөгийг байрнаасаа нэг гараар ойрхон зайд шидэж харуулдаг.	Жижиг бөмбөгийг нэг гараар байрнаасаа дунд зэргийн хол зайд шидэж харуулдаг.	Жижиг бөмбөгийг байрнаасаа нэг гараар нэлээд хол зайд шидэж харуулдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
1	3.1б. Багшийн тусламжтайгаар өөрийн биеийн өндөр ба жинг хэмжих, өсөлтөө тодорхойлох	Сурагч өөрийн биеийн өндөр, жинд үндэслэн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтээ харьцуулна.
	3.1в. Удаан сууснаас чилж ядарвал алжаал тайлах цогц дасгалыг ашиглах 3.1г. Гар, хөл, их биеийн хөдөлгөөн хосолсон шинэ дасгал, богино дээстэй, зөөлөн бөмбөгтэй, саваа модтой, цацагтай цогц дасгалыг ганцаар болон хосоор гүйцэтгэх	- Сурагч алжаалаа тайлахдаа биеийн ерөнхий хөгжлийн цогц дасгалыг ашиглана.
	3.1д. Дүүжигнэлтээс хөлөө нугалан өргөж өнцөг барих, гараа нугалан дүүжигнэх, их биеэ савах дасгалыг гүйцэтгэх 3.1е. Тэнцвэрийн чадавхаа сайжруулахдаа жижиг тавцан дээр нэг хөлөөрөө зогсох, үсэрч 180° эргэн, тэнцвэрээ хадгалж буух, бие биенийхээ тэнцвэрийг алдагдуулах хөдөлгөөнт тоглоомыг ашиглах 3.1ж. Гар, их бие, хөлийн хүчийг хөгжүүлэхдээ 700-800 г жинтэй хүндрүүлэгчийг ашиглах 3.1з. Хосоороо сунгалтын дасгал гүйцэтгэхдээ нөхөртөө туслах, аюулгүй байдлаа хангах аргыг хэрэгжүүлэх 3.1и. Шагайн тоглоомын дүрмийг өөрийн үгээр тайлбарлах, биеийн тэнцвэр, хөдөлгөөний эвсэл, уян чадавхаа хөгжүүлэхдээ хэвтээ, суугаа, зогсоо байдлаас дурын аргаар шагайг няслах, шүүрэх дасгал, тоглоомыг ашиглах	- Сурагч хүч, хөдөлгөөний эвсэл, уян хатны дасгалыг гүйцэтгэж, эдгээр чадавхын хөгжлөө харуулна.

3.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өөрийн биеийн өндөр, жинд үндэслэн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтээ харьцуулна.	Биеийн өндөр, жингээ багшийн тусламжтай хэмжиж, эдгээр үзүүлэлтийг 8 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, өөрийн бие бялдрын хөгжлийн түвшинг хэлж чаддаг.
2	Сурагч алжаал тайлахдаа биеийн ерөнхий хөгжлийн цогц дасгалыг ашиглана.	Биеийн ерөнхий хөгжлийн дээстэй 48 тоот цогц дасгалыг ганцаар болон хосоор гүйцэтгэдэг.
3	Сурагч хүч, хөдөлгөөний эвсэл, уян хатны дасгалыг гүйцэтгэж, эдгээр чадавхын хөгжлөө харуулна.	Гар, хөл, их биеийн хүчний дасгалыг өөрийн дээд хүчээр гүйцэтгэдэг.
		Биеийн тэнцвэрээ хадгалан дасгал гүйцэтгэдэг.
		Аюулгүй байдлаа хангаж, хосоороо уян хатны дасгалыг гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Биеийн өндөр, жингээ багшийн тусламжтай хэмжиж, эдгээр үзүүлэлтийг 8 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, өөрийн бие бялдрын хөгжлийн түвшинг хэлж чаддаг.	Багшийн тусламжтайгаар хэмжсэн биеийн өндөр ба жингийн үзүүлэлтээ хэлдэг.	Биеийн өндөр ба жингийн хэмжээнд үндэслэн, өөрийн бие бялдрын хөгжил нь ямар түвшинд байгааг ойролцоогоор хэлдэг.	Биеийн өндөр ба жингийн хэмжээнд үндэслэн, өөрийн бие бялдрын хөгжил нь ямар түвшинд байгааг ойлгомжтой хэлдэг.	Биеийн өндөр ба жингийн хэмжээнд үндэслэн, өөрийн бие бялдрын хөгжил нь ямар түвшинд байгааг ойлгомжтой, тодорхой хэлдэг.
Биеийн ерөнхий хөгжлийн дээстэй 48 тоот цогц дасгалыг ганцаар болон хосоор гүйцэтгэдэг.	Биеийн ерөнхий хөгжлийн дээстэй 48 тоот цогц дасгалыг багшийг дуурайн гүйцэтгэдэг.	Биеийн ерөнхий хөгжлийн дээстэй 48 тоот цогц дасгалыг багшийн тоололт, ажиглалт, сануулгын дор гүйцэтгэдэг.	Аюулгүй байдлыг ханган, дээстэй 48 тоот цогц дасгалыг бие даан гүйцэтгэдэг.	Хоорондын зайгаа тохируулж аюулгүй байдлыг ханган, дээстэй 48 тоот цогц дасгалыг бие дааж болон хосоороо нэгэн зэрэг гүйцэтгэдэг.
Биеийн тэнцвэрээ хадгалан дасгал гүйцэтгэдэг.	Тэнцвэрийн дасгалд биеийн тэнцвэрээ хадгалж чадахгүйгээр дасгалыг 2-3 удаа гүйцэтгэхийг оролддог.	Тэнцвэрийн дасгалд биеийн тэнцвэрээ нэлээд өөрчилж дасгалыг гүйцэтгэдэг.	Тэнцвэрийн дасгалд биеийн тэнцвэрээ бага зэрэг алдаж дасгалыг гүйцэтгэдэг.	Тэнцвэрийн дасгал гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрээ огт алдахгүйгээр дасгалыг бүрэн дуусгадаг.
Гар, хөл, их биеийн хүчний дасгалыг өөрийн дээд хүчээр гүйцэтгэдэг.	Хүчний дасгалыг энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс доогуур үзүүлэлттэй гүйцэтгэдэг.	Хүчний дасгалыг энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээр гүйцэтгэдэг.	Хүчний дасгалыг энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс бага зэрэг дээш үзүүлэлттэй гүйцэтгэдэг.	Хүчний дасгалыг энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс нэлээд дээш үзүүлэлттэй гүйцэтгэдэг.
Аюулгүй байдлаа хангаж, хосоороо уян хатны дасгалыг гүйцэтгэдэг.	Аюулгүй байдлаа тооцолгүй хосоороо сунгалтын дасгалыг бага далайцтай гүйцэтгэдэг.	Аюулгүй байдлаа хангаж, хосоороо сунгалтын дасгалыг дунд зэргийн далайцтай гүйцэтгэдэг.	Аюулгүй байдлаа хангаж, хосоороо сунгалтын дасгалыг дээд хэмжээнд ойртсон далайцтай гүйцэтгэдэг.	Аюулгүй байдлаа бүрэн хангаж, хосоороо сунгалтын дасгалыг хамгийн дээд далайцтай гүйцэтгэдэг.

3.2. Алхах, гүйх үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	3.2а. Зөв гүйж сурахдаа нарийн зурвас дээгүүр гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхах, гүйх дасгалыг ашиглах 3.2б. Вальс алхаа ба гимнастикийн сандал дээрх саадыг давж алхах аргыг харуулах 3.2в. Уралдан гүйж тоглохдоо чиглэлээ өөрчлөн хурдтай гүйх чадвараа ашиглах 3.2г. Санамсаргүй дохиог ялгаж, уг дохиогоор ойрхон зайд огцом хурдтай гүйж харуулах	Алхах, Гүйх	- Сурагч жижиг саад дээгүүр даван, нарийн зурвасаар гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхаж харуулна.
	3.2д. Гүйлтийн хурдаа хөгжүүлэхдээ тус тусын замаар 30 м хүртэл зайд дээд хурдаар гүйх дасгалыг ашиглах 3.2е. 500 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах		- Сурагч босоо гараанаас 30м зайд дээд хурдаар гүйх ба алхаа, гүйлтийг хослуулан 500м зайг туулж харуулна.

3.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч жижиг саад дээгүүр даван, нарийн зурвасаар гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхаж харуулна.	Нарийн зурвас дээрх саадыг даван, гарын янз бүрийн хөдөлгөөнтэй алхдаг.
2	Сурагч босоо гараанаас 30 м зайд дээд хурдаар гүйх ба алхаа, гүйлтийг хослуулан 500 м зайг туулж харуулна.	Босоо гараанаас 30 м зайд өөрийн дээд хурдаар гүйдэг.
		Алхах, гүйхийг хослуулан 500 м зайг туулдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Нарийн зурвас дээрх саадыг даван, гарын янз бүрийн хөдөлгөөн гүйцэтгэж алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан зарим саадыг даван, гарын 2-оос цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаас нэлээд хазайн алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан ихэнх саадыг даван, гарын 3-аас цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаас бага зэрэг хазайн алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан ихэнх саадыг даван, гарын 4-өөс цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаас хазайлгүй алхдаг.	Нарийн зурвас дээр байрлуулсан бүх саадыг даван, гарын 5-аас цөөнгүй хөдөлгөөн хийж, зурвасаас хазайлгүй алхдаг.
Босоо гараанаас 30 м зайд өөрийн дээд хурдаар гүйдэг.	30 м зайд бага хурдтай гүйдэг.	30 м зайд дунд зэргийн хурдтай гүйдэг.	30 м зайд нэлээд хурдтай гүйдэг.	Өөрийгөө сайн дайчлан, 30 м зайд дээд хурдаараа гүйдэг.
Алхах, гүйхийг хослуулан 500 м зайг туулдаг.	Ихэнх зайд алхаж, багахан зайд гүйж 500 м замыг туулдаг.	Нийт зайн хагасыг нь гүйж, хагасыг нь алхаж, 500 м замыг туулдаг.	Ихэнх зайд гүйж, багахан зайд алхаж 500 м замыг туулдаг.	Огт алхахгүй гүйж, 500 м зайг туулдаг

3.3.ҮСРЭХ, ХАРАЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	3.3а. Дээш ба урагш үсэрч харайхын ялгааг биеийн үйлдлээр үзүүлж, тодруулах, үсрэлтийн дасгал, тоглоомын ач холбогдлыг эргэн санах 3.3г. Дээс, резин, бөмбөг ашиглан үсрэх, өндөр тавцан дээр зогсоод үсэрч эргэх дасгал, тоглоомоор хөлийн түлхэлт, савалтыг сайжруулах 3.3б. Байрнаас уртад 95-105 см-ээс хол харайж харуулах 3.3в. 8-10 м зайнаас гүйж, нэг хөлөөр түлхэн уртад 2 м-ээс хол харайж үзүүлэх 3.3д. Гүйлтээс нэг хөлөөр түлхэн, 160-190 см өндөрт дүүжилсэн зүйлд нэг гараар хүрч харуулах	Үсрэх, Харайх	- Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас ба гүйлтээс уртад аль болох хол харайж харуулна.

3.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас ба гүйлтээс уртад аль болох хол харайж харуулна.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас уртад аль болох хол харайдаг. Хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, гарын савалттайгаар, уртад аль болох хол харайдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас уртад аль болох хол харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс доогуур үзүүлэлттэй харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээр харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг зөв хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс бага зэрэг илүү үзүүлэлттэй харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг зөв хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс нэлээд илүү үзүүлэлттэй харайдаг.
Хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, гарын савалттайгаар, уртад аль болох хол харайдаг.	Дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж уртад харайдаг.	Дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж уртад харайдаг.	Хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж уртад харайдаг.	Нэлээд хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн буухдаа аль болох хол харайдаг.

3.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	3.4а. Шидэлтийн дасгалыг гүйцэтгэхдээ жижиг цагариг, урт богино жад, цаасан саваа, тавганцарыг барих ба шидэх аргуудыг хэрэгжүүлэх 3.4в. Жижиг, том бөмбөгөөр 2-5 м зайд буй байг онож, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх 3.4б. Том бөмбөгийг байрандаа ба алхалтаас залж харуулах	Шидэлт	- Сурагч жижиг, том бөмбөгөөр бай онож шидэн, хөдөлгөөний эвслээ харуулна.

3.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч жижиг, том бөмбөгөөр бай онож шидэн, хөдөлгөөний эвслээ харуулна.	Янз бүрийн зайд байрлуулсан байг жижиг ба том бөмбөгөөр шидэж онодог.
2	Сурагч том бөмбөгөөр тоглохдоо бөмбөг дамжуулах аргуудыг ашиглана.	Том бөмбөгийг дамжуулж тоглохдоо дамжуулах аргыг оновчтой сонгож, идэвхтэй, үр дүнтэй тоглодог.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Янз бүрийн зайд байрлуулсан байг жижиг ба том бөмбөгөөр шидэж онодог.	Тодорхой зайд байрлуулсан байруу бөмбөгийг шидэж, 60%-ийн үзүүлэлттэй онодог.	Тодорхой зайд байрлуулсан байруу бөмбөгийг шидэж, 70%-ийн үзүүлэлттэй онодог.	Тодорхой зайд байрлуулсан байруу бөмбөгийг шидэж, 80%-ийн үзүүлэлттэй онодог.	Тодорхой зайд байрлуулсан байруу бөмбөгийг шидэж, 90%-иас дээш үзүүлэлттэй онодог.
Том бөмбөгийг дамжуулж тоглохдоо дамжуулах аргыг оновчтой сонгож, идэвхтэй, үр дүнтэй тоглодог.	Том бөмбөгийг зөвхөн нэг аргаар дамжуулж тоглоомд оролцдог.	Том бөмбөгийг дамжуулж тоглохдоо дамжуулах аргаа хааяа зөв сонгож, тоглоомд оролцдог.	Том бөмбөгийг дамжуулж тоглохдоо дамжуулах аргаа ихэвчлэн зөв сонгож, тоглоомд идэвхтэй оролцдог.	Том бөмбөгийг дамжуулж тоглохдоо дамжуулах аргаа байнга зөв сонгож, тоглоомд идэвхтэй оролцон, ихэнхдээ хождог.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	4.1а. Командаар нэг эгнээнээс гурван эгнээнд жагсах, заал талбайн төв рүү гурваар орох, алхалтан дундаа баруун, зүүн тийш эргэх, цуваа жагсаалд баруун, зүүн мөр түрүүлж алхалтыг гүйцэтгэх 4.1б. Биеийн тамирын хичээлийн үед мөрдөх аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэх, биеийн жин, өндрийг хэмжих аргыг ашиглан өөрийн өндөр, жингээ тодорхойлох	Ахуйн хэрэгцээт дасгал	- Сурагч биеийн өндөр, жинг хэмжих аргыг ашиглан өөрийн бие бялдрын үзүүлэлтээ харьцуулан тодорхойлно.
	4.1в. Хөдөлгөөний эвсэл ба гарын хүчээ хөгжүүлэхдээ гимнастикийн саваатай цогц дасгал, янз бүрийн хэмжээний алчууртай дасгалыг багаараа хамтран гүйцэтгэх, үзүүлэх тоглолтооролцох 4.1г. Хэвлийн булчингийн хүчээ хөгжүүлэх дүүжигнэлтээс хөлөө шулуун өргөж, буулгах дасгалыг ашиглах 4.1д. Тодорхой хугацаанд гурван цэгийн ба далан дээр зогсолтыг гүйцэтгэх, урагш ба арагш өнхрөлттэй хослуулан эвлүүлэг болгон хийж харуулах 4.1е. Зэрэгцүүлж тавьсан дамжуурга буюу нам савлуурт тулалтаас гараа зөөн, урагш ба арагш шилжилт гүйцэтгэх, 800-1000 г жинтэй гантельтай дасгалаар хүчийг хөгжүүлэх		- Сурагч хөдөлгөөний эвсэл, гарын хүчээ хөгжүүлэхдээ биеийн ерөнхий хөгжлийн хэрэгсэлтэй цогц дасгалыг ашиглана.

4.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч биеийн өндөр, жинг хэмжих аргыг ашиглан өөрийн бие бялдрын үзүүлэлтээ харьцуулан тодорхойлно.	Биеийн өндөр, жинг багштай хамтран хэмжиж, 9 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, бие бялдрын хөгжлийн түвшингээ хэлж чаддаг.
2	Сурагч хөдөлгөөний эвсэл гарын хүчээ хөгжүүлэхдээ биеийн ерөнхий хөгжлийн хэрэгсэлтэй цогц дасгалыг ашиглана.	Биеийн ерөнхий хөгжлийн саваатай цогц дасгалыг 6-8 сурагч багаараа гүйцэтгэдэг.
3	Сурагч аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэн, сургалтын дасгалыг акробатикийн эвлүүлэгтэй холбон гүйцэтгэж харуулна.	Аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлж, гурван цэгийн зогсолт, далан дээр зогсолт, урагш ба арагш өнхрөлт зэрэг акробатикийн техникийг нуман тулгуур, төөлж суух дасгалтай эвлүүлэг болгон гүйцэтгэж харуулдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Биеийн өндөр, жинг багштай хамтран хэмжиж, 9 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, бие бялдрын хөгжлийн түвшингээ хэлж чаддаг.	Багшийн ба бусдын дэмжлэгтэйгээр хэмжсэн өөрийн биеийн өндөр, жингийн үзүүлэлтийг зөв хэлдэг.	Багшийн ба бусдын дэмжлэгтэйгээр хэмжсэн өөрийн биеийн өндөр, жингийн үзүүлэлтийг 9 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, бие бялдрын хөгжлийн түвшингээ ойролцоогоор хэлдэг.	Багшийн ба бусдын дэмжлэгтэйгээр хэмжсэн өөрийн биеийн өндөр, жингийн үзүүлэлтийг 9 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, тооцоолж, бие бялдрын хөгжлийн түвшингээ зөв хэлдэг.	Багшийн ба бусдын дэмжлэгтэйгээр хэмжсэн өөрийн биеийн өндөр, жингийн үзүүлэлтийг 9 настай монгол хүүхдийн жишиг үзүүлэлттэй харьцуулан, бие бялдрын хөгжлийн түвшингээ зөв тооцоолж, ойлгомжтой, тодорхой хэлдэг.
Биеийн ерөнхий хөгжлийн саваатай 64 тоот цогц дасгалыг 6-8 сурагч багаараа гүйцэтгэдэг.	Биеийн ерөнхий хөгжлийн саваатай 64 тоот цогц дасгалыг багаараа гүйцэтгэсэн боловч бие биенийгээ дуурайн, олон алдаа гаргадаг.	Биеийн ерөнхий хөгжлийн саваатай 64 тоот цогц дасгалыг багаараа нэгэн зэрэг, гүйцэтгэхдээ удирдагч сурагчийн чиглүүлгийг ашиглан, цөөн алдаатай гүйцэтгэдэг.	Биеийн ерөнхий хөгжлийн саваатай 64 тоот цогц дасгалыг багаараа нэгэн зэрэг, гүйцэтгэхдээ удирдагч сурагчийн чиглүүлгийг ашиглан зөв гүйцэтгэдэг.	Биеийн ерөнхий хөгжлийн саваатай 64 тоот цогц дасгалыг багаараа нэгэн зэрэг, огт алдаагүй, цэвэрхэн гүйцэтгэдэг.
Аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлж, гурван цэгийн зогсолт, далан дээр зогсолт, урагш ба арагш өнхрөлт зэрэг акробатикийн техникийг нуман тулгуур, төөлж суух дасгалтай эвлүүлэг болгон гүйцэтгэж харуулдаг.	Аюулгүй байдлын алдаа гаргасан, акробатикийн эвлүүлэгт багтсан техникүүдэд 4-өөс олон алдаа гаргасан, сунгалтын дасгалыг бага далайцтай гүйцэтгэж харуулдаг.	Аюулгүй байдлын алдаа гаргаагүй боловч акробатикийн эвлүүлэгт багтсан техникүүдэд 3-4 алдаа гаргасан, сунгалтын дасгалыг дунд зэргийн далайцтай гүйцэтгэж харуулдаг.	Аюулгүй байдлаа хангаж, акробатикийн эвлүүлгийг дарааллын дагуу гүйцэтгэсэн боловч 1-2 алдаатай, сунгалтын дасгалыг их далайцтай гүйцэтгэж харуулдаг.	Аюулгүй байдлаа бүрэн хангаж, акробатикийн эвлүүлгийг дарааллын дагуу зөв, сунгалтын дасгалыг дээд далайцтай гүйцэтгэж харуулдаг.

4.2. АЛХАХ, ГҮЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
2	4.2а. Янз бүрээр алхах чадвараа сайжруулан, 300-400 м зайд хурдтай алхаж харуулах	Алхах, Гүйх	- Сурагч гүйлтийн гурван сонгомол дасгалыг техникийн дагуу гүйцэтгэнэ.
	4.2б. Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх зэрэг гүйлтийн сонгомол дасгалыг техникийн дагуу гүйцэтгэх		
	4.2в. 10-15 м хүртэл ойрхон зайд гүйхдээ гүйх чиглэл ба хурдаа огцом өөрчлөх		- Сурагч 40 м зайд дээд хурдаар гүйх ба алхаа гүйлтийг хослуулан 500-600 м зайд туулж харуулна.
	4.2г. Шулуун замд 40 м зайд дээд хурдаар, 3-4 удаа давтан гүйж харуулах 4.2д. Охид 500 м, хөвгүүд 600 м зайг туулахдаа алхаа ба зөөлөн гүйлтийг хослуулан ашиглах		

4.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гүйлтийн гурван сонгомол дасгалыг техникийн дагуу гүйцэтгэнэ.	Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх гүйлтийн сонгомол дасгалыг техникийн дагуу гүйцэтгэдэг.
2	Сурагч 40 м зайд дээд хурдаар гүйх ба алхаа гүйлтийг хослуулан 500-600 м зайд туулж харуулна.	Босоо гараанаас 40 м зайд өөрийн дээд хурдаар гүйдэг.
		Алхах, гүйхийг хослуулан 500-600 м зайд туулдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх гүйлтийн сонгомол дасгалыг техникийн дагуу зөв гүйцэтгэдэг.	Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх гүйлтийн сонгомол дасгал бүрийн техникийг их алдаатай гүйцэтгэдэг.	Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх гүйлтийн сонгомол дасгал бүрийн техникийг цөөн алдаатай гүйцэтгэдэг.	Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх гүйлтийн сонгомол дасгал бүрийн техникийг хичээж, зөв гүйцэтгэдэг.	Өвдөг өндөр өргөж гүйх, хөлөөс хөлд үсрэх, шилбээр арагш савж гүйх гүйлтийн сонгомол дасгал бүрийг техникийн дагуу маш зөв, өөртөө итгэлтэй, чөлөөтэй гүйцэтгэдэг.
Босоо гараанаас 40 м зайд өөрийн дээд хурдаар гүйдэг.	40 м зайд бага хурдтай гүйдэг.	40 м зайд дунд зэргийн хурдтай гүйдэг.	40 м зайд нэлээд хурдтай гүйдэг.	Өөрийгөө сайн дайчлан, 40 м зайд дээд хурдаараа гүйдэг.
Алхах, гүйхийг хослуулан 500-600 м зайд туулдаг.	Ихэнх зайд алхаж, багахан зайд гүйж охид 500 м, хөвгүүд 600 м замыг туулдаг.	Нийт зайн хагасыг нь гүйж, хагасыг нь алхаж, охид 500 м, хөвгүүд 600м замыг туулдаг.	Ихэнх зайд гүйж, багахан зайд алхаж охид 500 м, хөвгүүд 600 м замыг туулдаг.	Огт алхахгүй гүйж, охид 500 м хөвгүүд 600м зайд туулдаг.

4.3. ҮСРЭХ, ХАРАЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
3	4.3а. Үсрэлт харайлтын дасгал хийх үед аюулгүй байдлын дүрмийг хэрэгжүүлэх 4.3б. Хоёр хөлөөр түлхэн модон морь, тавцан дээр тулж явган суух, суултаас хотойлттой үсэрч буух техникийг гүйцэтгэх 4.3в. Ташуу гүйлтээс нэг хөлөөр түлхэн, хөвгүүд модон морь, охид 60 см өндөр тавцан дээр гарч, гараа ардаа тулан сууж харуулах 4.3г. Үсэрч, харайх дасгал, тоглоомоор хөлийн түлхэлтийн хүч, хурд, хөдөлгөөний эвслийг хөгжүүлэх	Үсрэлт, Харайлт	- Сурагч хөлийн түлхэлт, гарын савалтыг ашиглан, байрнаас ба гүйлтээс уртад хол харайж харуулна.
	4.3д. Гүйлтээс нэг хөл дээр дэгдэж үсрэн 10 м зайг туулах, гүйлтээс түлхэн 40-50 см өндөр саадыг давах, 60-80 см өндрөөс үсэрч зөөлөн буух, 170-190 см өндөрт өлгөсөн зүйлд нэг гараар хүрэх, байрнаас уртад 100-125 см харайх нормыг биелүүлэх 4.3е. 10-12 м зайнаас гүйн уртад 150-200 см хол харайж харуулах		

4.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гарын савалт, хөлийн түлхэлтийг ашиглан, байрнаас ба гүйлтээс уртад хол харайж харуулна.	Хөлийн түлхэлт, гарын савалтыг ашиглан, байрнаас уртад аль болох хол харайдаг.
		10-12 м зайнаас хурдтай гүйж, нэг хөлөөр түлхэн, гарын савалттайгаар, уртад хол харайдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Хөлийн түлхэлт, гарын савалтыг ашиглан, байрнаас уртад аль болох хол харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс доогуур үзүүлэлттэй харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээр харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг зөв хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс бага зэрэг илүү үзүүлэлттэй харайдаг.	Гарын савалт, хөлийн түлхэлтийг зөв хослуулан, байрнаас уртад харайх энэ насны сурагчдын дундаж үзүүлэлтээс нэлээд илүү үзүүлэлттэй харайдаг.
10-12 м зайнаас хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, гарын савалттайгаар, уртад хол харайдаг.	Охид 10 м, хөвгүүд 12 м зайнаас дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж уртад хол биш харайдаг.	Охид 10 м, хөвгүүд 12 м зайнаас дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж уртад хол биш харайдаг.	Охид 10 м, хөвгүүд 12 м зайнаас хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн бууж уртад хол харайхыг хичээдэг.	Охид 10 м, хөвгүүд 12 м зайнаас нэлээд хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн буухдаа аль болох хол харайдаг.

4.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
4	4.4а. Волейболын бөмбөгийг шидэх болон шилжилтээс дамжуулах аргаар хурд-хүчээ хөгжүүлэх	Шидэх, Дамжуулах	- Сурагч бөмбөг дамжуулах чадвараа ашиглан, волейболын бөмбөгөөр хана руу оновчтой дамжуулалт гүйцэтгэнэ.
	4.4б. Сагсан бөмбөгийг янз бүрийн бай руу дамжуулах, тоглохдоо оновчтой аргыг сонгох 4.4г. Хөл бөмбөгийг хөлөөрөө өнхрүүлэх, тогтоох аргуудыг ашиглах 4.4в. Хүчээ хөгжүүлэхдээ 600-800 гр жинтэй чихмэл бөмбөгийг байрнаас, 150 гр жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэж харуулах 4.4д. Жижиг бөмбөгөөр 2-5 м зайд буй байг онож, орон зайн баримжаа, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх, үнэлэх		- Сурагч жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэж харуулна.

4.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч бөмбөг дамжуулах чадвараа ашиглан, волейболын бөмбөгөөр хана руу оновчтой дамжуулалт гүйцэтгэнэ.	Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу дамжуулж байг оноод, доороос хоёр гараар барьж авдаг.
2	Сурагч жижиг бөмбөгийг гүйлтээс хол шидэж харуулна.	150 гр жинтэй жижиг бөмбөгийг гүйлтээс хол шиддэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу дамжуулж байг оноод, доороос хоёр гараар барьж авдаг.	Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулахдаа байг цөөн онодог, бөмбөгийг биедээ наан хоёр гараар барьж авдаг.	Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулахдаа 50%-д нь байг онодог, бөмбөгийг биедээ наан хоёр гараар барьж авдаг.	Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулахдаа ихэнх тохиолдолд байг онодог, бөмбөгийг хоёр гараар доороос тосон барьж авдаг.	Волейболын бөмбөгийг хоёр гараар дээрээс хана руу олон удаа дамжуулах бүртээ байг онодог ба бөмбөгийг хоёр гараар доороос тосон барьж авдаг.
150 гр жинтэй жижиг бөмбөгийг гүйлтээс хол шиддэг.	10 м зайд хурд багатай гүйж, мэдэгдэм зогсолттойгоор, 150 гр жижиг бөмбөгийг урагш, эсвэл нэлээд дээш чиглэлд шиддэг.	10 м зайд дунд зэргийн хурдтай гүйж, мэдэгдэм зогсолттойгоор, 150 гр жижиг бөмбөгийг урагш-дээш чиглэлд гараас гаргаж шиддэг.	10 м зайд хурдтай гүйлтээс, бага зэрэг зогсолттойгоор, 150 гр жижиг бөмбөгийг урагш-дээш чиглэлд гараас гаргаж, хүчтэй шиддэг.	10 м зайд хурдтай гүйлтээс, зогсолтгүйгээр, 150 гр жижиг бөмбөгийг урагш-дээш чиглэлд гараас гаргаж, маш хүчтэй шиддэг.

ТАВДУГААР БҮЛЭГ. V АНГИ

5.1. АХУЙН ХЭРЭГЦЭЭТ ДАСГАЛ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	5.1а. Заал, талбайн төв рүү дөрвөөр орох, алхалтан дунд эргэлтийг гүйцэтгэх	Ахуйн хэрэгцээт дасгал	- Сурагч өөрийн бие бялдрын хөгжлийг нөхөдтэйгээ хамтран хэмжиж, үзүүлэлтэнд гарсан өөрчлөлтийг тодорхойлно.
	5.1б. Нөхөдтэйгээ хамтран өөрийн биеийн өндөр ба жин, цээжний тойргийг хэмжих, өсөлтөө тодорхойлох		
	5.1в. Хүчээ хөгжүүлэхдээ дүүжигнэлтээс болон тулж хэвтсэн байдлаас сунаих, 800 г жинтэй гантельтай дасгалыг ашиглах		- Сурагч зогсоо, хэвтээ дүүжигнэлтээс суниаж харуулна.
	5.1г. Хөтлөлцөн зогссон байдлаас болон хосоороо урагш өнхрөлт хийх, акробатикийн дасгалыг эвлүүлэг болгон гүйцэтгэх		
	5.1д. Биеийн ерөнхий хөгжлийн гимнастикийн сандалтай дасгалыг гурвуулаа, дөрвүүлээ хамтран гүйцэтгэх 5.1е. Янз бүрийн байдлаас шагай шүүрч тоглох дүрмийг хэрэгжүүлэх		- Сурагч аюулгүй байдлаа ханган хосоор өнхрөлт гүйцэтгэнэ.

5.1.2. Үнэлгээний нэгж 1. Ахуйн хэрэгцээт дасгал суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч өөрийн бие бялдрын хөгжлийг нөхөдтэйгээ хамтран хэмжиж, үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тодорхойлно.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний тойргийг нөхөдтэйгээ хамтран хэмжиж, үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцоолдог.
2	Сурагч зогсоо, хэвтээ дүүжигнэлтээс суниаж харуулна.	Хөвгүүд зогсоо дүүжигнэлтээс, охид хэвтээ дүүжигнэлтээс олон удаа сунайдаг.
3	Сурагч аюулгүй байдлаа ханган хосоор өнхрөлт гүйцэтгэнэ.	Аюулгүй байдлаа хангаж, хосоор өнхрөлтийг гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Өөрийн биеийн өндөр, жин, цээжний тойргийг нөхөдтэйгээ хамтран хэмжиж, үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцоолдог.	Өөрийн биеийн жин, өндөр, цээжний тойргийг нөхөдтэйгээ хамтран хэмжихдээ багшийн дэмжлэгийг авдаг, өөрчлөлтүүдийг алдаатай тооцоолдог.	Өөрийн биеийн жин, өндөр, цээжний тойргийг нөхөдтэйгээ хамтран хэмжихдээ багшийн дэмжлэгийг авдаг, зарим үзүүлэлтийн өөрчлөлтийг тооцоолдог.	Өөрийн биеийн жин, өндөр, цээжний тойргийг нөхөдтэйгээ хамтран зөв хэмжиж, ихэнх үзүүлэлтийн өөрчлөлтийг тооцоолдог.	Өөрийн биеийн жин, өндөр, цээжний тойргийг нөхөдтэйгээ хамтран зөв хэмжиж, бүх үзүүлэлтийн өөрчлөлтийг бүрэн зөв тооцоолдог.

Хөвгүүд зогсоо дүүжигнэлтээс, охид хэвтээ дүүжигнэлтээс олон удаа сунайдаг.	Хөвгүүд зогсоо, охид хэвтээ дүүжигнэлтээс сунайхдаа ангийнхаа дээд үзүүлэлтээс 50% цөөн удаа сунайдаг.	Хөвгүүд зогсоо, охид хэвтээ дүүжигнэлтээс сунайхдаа ангийнхаа дээд үзүүлэлтээс 40% цөөн удаа сунайдаг.	Хөвгүүд зогсоо, охид хэвтээ дүүжигнэлтээс сунайхдаа ангийнхаа дээд үзүүлэлтээс 20% цөөн удаа сунайдаг.	Хөвгүүд зогсоо, охид хэвтээ дүүжигнэлтээс сунайхдаа ангийнхнаасаа хамгийн олон удаа сунайдаг.
Аюулгүй байдлаа хангаж, хосоор өнхрөлтийг гүйцэтгэдэг.	Зэрэгцэн явган сууж хосоор өнхрөхдөө 5-с дээш алдаа гаргасан, эсвэл өнхөрч чадаагүй.	Зэрэгцэн явган сууж дотор талын гараа давхарлан, гадна талын гарын алгаар матрас дээр тулан хосоор өнхрөхдөө үйлдлийг 3-4 алдаатай гүйцэтгэсэн.	Зэрэгцэн явган сууж дотор талын гараа давхарлан, гадна талын гарын алгаар матрас дээр тулан, хосоор өнхрөхдөө үйлдлийг 1-2 алдаатай гүйцэтгэсэн.	Зэрэгцэн явган сууж дотор талын гараа давхарлан, гадна талын гарын алгаар матрас дээр тулан, хосоор өнхрөхдөө бүх үйлдлийг зөв гүйцэтгэсэн.

5.2. АЛХАХ, ГҮЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
2.	5.2а. Спорт алхаагаар 100-200 м зайд хурдтай алхаж харуулах 5.2б. Дохиогоор гараанаас гарах чадвараа ашиглан, босоо гараанаас ба тулж тонгойсон байдлаас 50 м зайд дээд хурдаар гүйж харуулах 5.2в. Янз бүрийн чиглэлд сагсан бөмбөгийн залалт гүйцэтгэх 5.2г. Өнхөрч буй хөл бөмбөгийг хөөж гүйцэх, хурдтай гүйх тоглоом ба давтан гүйлтээр хурд, тэсвэрээ хөгжүүлэх 5.2д. Холын зайд жигд гүйх аргыг ашиглан, 1000 м зайд жигд хурдаар гүйж үзүүлэх 5.2а. Спорт алхаагаар 100-200 м зайд хурдтай алхаж харуулах 5.2б. Дохиогоор гараанаас гарах чадвараа ашиглан, босоо гараанаас ба тулж тонгойсон байдлаас 50 м зайд дээд хурдаар гүйж харуулах 5.2в. Янз бүрийн чиглэлд сагсан бөмбөгийн залалт гүйцэтгэх 5.2г. Өнхөрч буй хөл бөмбөгийг хөөж гүйцэх, хурдтай гүйх тоглоом ба давтан гүйлтээр хурд, тэсвэрээ хөгжүүлэх 5.2д. Холын зайд жигд гүйх аргыг ашиглан, 1000 м зайд жигд хурдаар гүйж үзүүлэх	Алхах, Гүйх	- Сурагч босоо гараанаас 50 м зайд дээд хурдаар гүйх ба 1000 м зайд жигд хурдаар гүйж харуулна.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

5.2.1. Үнэлгээний нэгж 2. Алхах, гүйх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч босоо гараанаас 50 м зайд дээд хурдаар гүйх ба 1000 м зайд жигд хурдаар гүйж харуулна.	Босоо гараанаас 50 м зайд дээд хурдаар гүйдэг.
		Босоо гараанаас 1000 м зайд жигд хурдаар гүйдэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Босоо гараанаас 50 м зайд дээд хурдаар гүйдэг.	Босоо гараанаас 50 м зайд бага хурдтай гүйдэг.	Босоо гараанаас 50 м зайд дунд зэргийн хурдтай гүйдэг.	Босоо гараанаас 50 м зайд нэлээд хурдтай гүйдэг.	Босоо гараанаас 50 м зайд дээд хурдаараа гүйдэг.
Босоо гараанаас 1000 м зайд жигд гүйдэг.	1000 м зайг туулахдаа нийт зайн 50%-г алхаж, үлдсэн зайд гүйдэг.	1000 м зайг туулахдаа нийт зайн 30-40%-г алхаж, үлдсэн зайд гүйдэг.	1000 м зайг туулахдаа жигд бус хурдаар гүйдэг.	1000 м зайг туулахдаа бүгдийг нь жигд хурдаар гүйдэг.

5.3. ҮСРЭХ, ХАРАЙХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
3.	5.3а. Гүйлтээс уртад харайх аргыг эргэн санаж, уртын харайлтын техникийг 4 хэсэгт хувааж тайлбарлах, гүйлтээс уртад 200-250 см хол харайж харуулах 5.3б. Гүйлтээс өндөрт харайх аргыг эргэн санаж, өндрийн харайлтын техникийг 4 хэсэгт хувааж тайлбарлах, гүйлтээс өндөрт 60-80 см харайж харуулах 5.3в. Эргүүлж буй дээсэнд орж үсрэн, ганцаараа ба багаараа дээсдэж тоглох дүрмийг хэрэгжүүлэх, хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх 5.3г. Гүйлтээс 60-80 см өндөр тавцан дээр хоёр гараар тулан, хөл салгаж харайн саадыг давж харуулах 5.3д. Өндрөөс үсэрч буунгуут 20-30 см өндөр тавцанд үсэрч гарах, хөлөөс хөлд үсрэн 20 м зайг туулах, нэг хөл дээр дэгдэж үсрэн 15 м зайг туулах, байрнаас уртад 110-130 см харайх нормыг биелүүлэх	Үсрэх, Харайх	- Сурагч гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг тайлбарлаж, уртад хол харайж харуулна.

5.3.1. Үнэлгээний нэгж 3. Үсрэх, харайх суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг тайлбарлаж, уртад хол харайж харуулна.	Гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг нэрлэн, хэсэг бүрийн ач холбогдлыг тайлбарладаг.
2		10-12 м гүйлтээс уртад хол харайдаг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг нэрлэн, хэсэг бүрийн ач холбогдлыг тайлбарладаг.	Гүйлтээс уртад харайх техникийн хэсгүүдийг алдаатай нэрлэж, хэсэг бүрийн үйлдлийн ач холбогдлыг тайлбарлахыг оролддог.	Гүйлтээс уртад харайх техникийн хэсгүүдийг зөв нэрлэж, хэсэг бүрийн үйлдлийн ач холбогдлыг тайлбарлахыг оролддог.	Гүйлтээс уртад харайх техникийн хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэж, хэсэг бүрийн үйлдлийн ач холбогдлыг биеийн тамирын хэлээр бүрэн бус тайлбарладаг.	Гүйлтээс уртад харайх техникийн хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэж, хэсэг бүрийн үйлдлийн ач холбогдлыг биеийн тамирын хэлээр оновчтой бүрэн тайлбарладаг.
10-12 м гүйлтээс уртад хол харайдаг.	12- 14 м зайнаас хурд багатай, том жижиг алхан гүйж, нэг хөлөөр түлхэн, агаарт нисэлтийг тодорхой үзүүлэлгүй, хоёр хөлөө зэрэгцүүлэн буулгаж уртад хол биш харайдаг.	12-14 м зайнаас дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр түлхэн, агаарт нисэлтийг тодорхой үзүүлэлгүй, хоёр хөлөө зэрэгцүүлэн буулгаж уртад хол биш харайдаг.	12-14 м зайнаас дунд зэргийн хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн буухдаа уртад хол биш харайдаг.	12-14 м зайнаас маш хурдтай гүйлтээс нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт нисэлт үзүүлж, хоёр хөлөө зэрэгцүүлэн буухдаа нэлээд хол харайдаг.

5.4. ШИДЭХ, ДАМЖУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
4.	5.4а. Хөл бөмбөгийг шагайн дотор талаар өшиглөх, өнхөрч ирсэн бөмбөгийг хөлийн улаар тогтоох техникийг гүйцэтгэх 5.4б. Волейболын бөмбөгийг хоёр гараар шидэж тор давуулахдаа гар-мөрний хүчээ ашиглах 5.4в. 1.5 м өндөр бай руу жижиг бөмбөгийг, 2-2.5 м өндөр бай руу сагсан бөмбөгийг оновчтой шидэлт гүйцэтгэх	Шидэх, Дамжуулах	- Сурагч цээжний орчмоос сагсан бөмбөгийг дамжуулах аргыг 2-3 м зайнаас үр дүнтэй хэрэгжүүлнэ.
	5.4г. Сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулах техникээ сайжруулж, 2-3 м зайнаас цээжний орчмоос хана руу дамжуулан шаланд ойлгон барьж авах аргыг хэрэгжүүлэх 5.4д. Хурдтай гүйлтээс жижиг бөмбөгийг хол шидэж харуулах 5.4е. Жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцож, тэмцээний дүрмийг биелүүлэх		- Сурагч жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэн, тэмцээнд оролцоно.

5.4.1. Үнэлгээний нэгж 4. Шидэх, дамжуулах суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч цээжний орчмоос сагсан бөмбөгийг дамжуулах аргыг 2-3 м зайнаас үр дүнтэй хэрэгжүүлнэ.	Сагсан бөмбөгийг хоёр гараар цээжний орчмоос хана руу дамжуулж байг онон, шаланд ойлгон барьж авдаг.
2	Сурагч жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэн, тэмцээнд оролцоно.	Тэмцээний дүрмийг тайлбарлаж, хурдтай гүйлтээс бөмбөгийг хол шиддэг.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Сагсан бөмбөгийг хоёр гараар цээжний орчмоос хана руу дамжуулж байг онон шаланд ойлгон барьж авдаг.	2 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг цөөн удаа оновчтой гүйцэтгэдэг.	2 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг цөөн удаа оновчтой гүйцэтгэдэг.	2.5 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг олон удаа оновчтой гүйцэтгэдэг.	3 м зайнаас сагсан бөмбөгийг цээжний орчмоос хоёр гараар дамжуулан ханан дээрх байг онож, шаланд ойлгон барьж авах дасгалыг олон удаа оновчтой, зөв гүйцэтгэдэг.
Тэмцээний дүрмийг тайлбарлаж, хурдтай гүйлтээс бөмбөгийг хол шиддэг.	Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг багшийн ба нөхдийнхөө тайлбараар хэрэгжүүлэн тэмцээнд оролцдог.	Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэхдээ анхааруулга авдаг, тэмцээнд оролцож, өөрийн амжилтаа бататгадаг.	Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг хэрэгжүүлэн, тэмцээнд оролцож, өөрийн амжилтаа ахиулдаг.	Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээний дүрмийг бүрэн хэрэгжүүлж, тэмцээнд амжилттай оролцон, тэргүүн байруудыг эзэлдэг.

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

БИЕЙН ТАМИР

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - VI анги
Хоёрдугаар бүлэг - VII анги
Гуравдугаар бүлэг - VIII анги
Дөрөвдүгээр бүлэг - IX анги

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

1.1. VI АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	6.1а. Өөрийн бие бялдрын хөгжлөө хэмжих, үнэлэх 6.1б. Бие бялдрын түвшин тогтоох сорилын шалгуураар өөрийн бие бялдрын чийрэгжилтийг хэмжих, үнэлэх	6.1. Бие бялдрын хөгжил	6.1.1. Сурагч өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтэд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.
2	6.2а. Спортын гимнастикийн хэрэглэлийг таньж тайлбарлах, акробатикийн хосоор өнхрөлт, гар дээр зогсолт, эвлүүлгийг гүйцэтгэх, бие биедээ туслан аюулгүй орчин бүрдүүлэх 6.2б. Спортын гимнастикийн чөлөөт хөдөлгөөний хувилбар гүйцэтгэх 6.2в. Өөрийн чадварыг бодитой тодорхойлж, гимнастикийн морь, ямаан дээгүүр харайж харуулах 6.2г. Уран сайхны гимнастикийн хэрэглэлийг таньж тайлбарлах, дээстэй дасгалаар хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх	6.2. Гимнастик	6.2.1. Сурагч аюулгүй орчин бүрдүүлэн, акробатикийн эвлүүлгийг чөлөөт хөдөлгөөнтэй хослуулан гүйцэтгэнэ. 6.2.2. Сурагч гимнастикийн хэрэглэлүүдийг таньж, морь, ямаа, дээс зэрэг хэрэглэлтэй дасгалыг техникийн дагуу гүйцэтгэнэ.
3	6.3а. Босоо гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйх, буухиалан гүйж тоглохдоо гүйлтийн техникээ хэрэглэх, буухианы үр дүнг шүүн тунгаах 6.3б. Халхалтыг давж гүйх техникээр 40 см өндөр халхалтыг даван 20 м гүйж харуулах 6.3в. Уртад “хөл нугалж” харайх техник задлалын хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдохыг тодорхойлох, 10-12 м гүйлтээс уртад “хөл нугалж” харайх техникийг гүйцэтгэх 6.3г. Хол зайд гүйхдээ бэрхшээлийг хэрхэн даван туулснаа өөрийн үгээр тодруулах, охид 1000 м, хөвгүүд 1200 м зайд жигд гүйх аргаар ерөнхий тэсвэрээ хөгжүүлэх	6.3. Хөнгөн атлетик	6.3.1. Сурагч гүйлтийн техникээ ашиглан 60 м зайд дээд хурдаар, 1000-1200 м зайд жигд гүйх ба буухиалан гүйж идэвхтэй тоглодог болно. 6.3.2. Сурагч уртад “хөл нугалж” харайх техник задлалын хэсгүүдийг нэрлэж, гүйцэтгэх дарааллыг хэлэн, 10-12 м урьдчилсан гүйлтээс уртад уг техникээр харайна.
4	6.4а. Сагсан бөмбөгийн үндсэн зогсолт, шилжилт, залалтын техникийг гүйцэтгэх 6.4б. 2-3 м зайнаас сагсан бөмбөгийг бие бие рүүгээ дамжуулах, өндөрт байрлуулсан бай руу шидэх техникийг гүйцэтгэх, тоглоомын дүрмийг биелүүлэх	6.4. Сагсан бөмбөг	6.4.1. Сурагч сагсан бөмбөгийн үндсэн зогсолт, шилжилт, залалтын техникийг гүйцэтгэн, өндөр бай руу шидэж тоглохдоо дүрмийг биелүүлнэ.
5	6.5а. Бөмбөгийг өшиглөх, тогтоох үеийн биеийн байрлал, хөлийн хөдөлгөөнийг сэргээн санаж, өнхөрч ба ойж ирсэн бөмбөгийг хөлийн улаар тогтоох, өшиглөх аргыг хэрэглэн үзүүлэх 6.5б. Цувруулж ба сөөлжүүлж байрлуулсан тэмдэгтийг сүлжиж бөмбөг залах техникийг гүйцэтгэх 6.5в. Өнхөрч, ойж, нисэж ирсэн бөмбөгийг хоёр гараар барих техникийг гүйцэтгэх 6.5г. Өнхөрч, ойж, нисэж ирсэн бөмбөгийг дамжуулах, заасан чиглэл рүү буцааж болон хаалга руу өшиглөх аргуудыг хөл бөмбөг тоглохдоо хэрэглэх	6.5. Хөл бөмбөг	6.5.1. Сурагч хөл бөмбөгийн өшиглөх, тогтоох, залах, барих техникийг гүйцэтгэн, тоглохдоо хэрэглэнэ.

6	6.6а. Волейболын үндсэн зогсолт, шилжилтийг техникийн дагуу гүйцэтгэх 6.6б. Бөмбөгийг доороос, дээрээс дамжуулах техникийг 3 м хүртэл зайнаас гүйцэтгэх	6.6. Волейбол	6.6.1. Сурагч волейболын үндсэн зогсолт, шилжилт, дамжуулалтын техникийг зөв гүйцэтгэнэ.
7	6.7а. Хурдан морины уралдааны онцлогийг тайлбарлах 6.7б. Хурдан морины цол, уяачид болон унаач хүүхдийн талаар мэдээлэл цуглуулан боловсруулах, хэлэлцэх	6.7. Үндэсний спорт-хурдан морь	6.7.1. Сурагч хурдан морины уралдааны талаар мэдээлэл цуглуулан хэлэлцэнэ.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

1.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдын хөгжил

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	6.1.1. Сурагч өөрийн бие бялдын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтэд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.	6.1.1.1. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний тойргийн үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцоолдог.
		6.1.1.2. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 11-12 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан, бие бялдын хөгжилдөө үнэлгээ өгдөг.
		6.1.1.3. “Хүн амын бие бялдын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын дасгалуудыг гүйцэтгэж, өөрийн насанд тохирох нормыг биелүүлдэг.
		6.1.1.4. Өөрийн бие бялдын чийрэгжилтэд үндэслэлтэй үнэлгээ өгдөг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.1.1.1. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний тойргийн үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцоолдог.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтэд мэдсэн боловч гарсан өөрчлөлтийг тооцоолж чадаагүй.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойрог зэрэг 4 үзүүлэлтээс 1-2 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг зөв тооцоолдог.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойрог зэрэг 4 үзүүлэлтээс 3 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг зөв тооцоолдог.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойрог зэрэг 4 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг бүгдийг бүрэн зөв тооцоолдог.
6.1.1.2. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 11-12 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан оновчтой биш үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ буруу танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 11-12 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан оновчтой биш үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ буруу танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 11-12 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан оновчтой биш үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ дутуу танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 11-12 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан зөв үнэлсэн боловч үнэлгээний үндэслэлээ ерөнхий байдлаар танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 11-12 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан өөрийн үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ тодорхой, ойлгомжтой танилцуулдаг.

6.1.1.3. “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын дасгалуудыг гүйцэтгэж, өөрийн насанд тохирох нормыг биелүүлдэг.	Сорилын дасгалуудын заримыг дунд ба доогуур түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 60-70 хувьтай хангадаг.	Сорилын дасгалуудын заримыг хангалттай ба дунд түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 71-80 хувьтай хангадаг.	Сорилын бүх дасгалыг хангалттай түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 81-90 хувьтай хангадаг.	Сорилын бүх дасгалыг хангалттай сайн түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 91-ээс дээш хувьтай хангадаг.
6.1.1.4. Өөрийн бие бялдрын чийрэгжилтэд үндэслэлтэй үнэлгээ өгдөг.	Сорилын зарим дасгалын шалгуурын дагуу өөртөө алдаатай үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ буруу танилцуулдаг.	Сорилын зарим дасгалын шалгуурын дагуу өөрийгөө үнэлэн, үнэлгээний үндэслэлээ дутуу танилцуулдаг.	Сорилын бүх дасгалын шалгуурын дагуу өөрийгөө зөв үнэлэн, үнэлгээний үндэслэлээ ерөнхий байдлаар танилцуулдаг.	Сорилын бүх дасгалын шалгуурын дагуу өөрийгөө зөв үнэлэн, үнэлгээний үндэслэлээ оновчтой, ойлгомжтой танилцуулдаг.

1.2.2. Үнэлгээний нэгж 2. Гимнастик

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
2	6.2.1. Сурагч аюулгүй орчин бүрдүүлэн, акробатикийн эвлүүлгийг чөлөөт хөдөлгөөнтэй хослуулан гүйцэтгэнэ.	6.2.1.1. Аюулгүй орчин бүрдүүлж, гар дээр зогсолт, хосоор өнхрөлт зэрэг акробатикийн дасгалыг техникийн дагуу гүйцэтгэдэг.
		6.2.1.2. Акробатикийн 4 дасгалыг чөлөөт хөдөлгөөнтэй хослуулсан эвлүүлгийг гүйцэтгэдэг.
	6.2.2. Сурагч гимнастикийн хэрэглэлүүдийг таньж, морь, ямаа, дээс зэрэг хэрэглэлтэй дасгалыг техникийн дагуу гүйцэтгэнэ.	6.2.2.1. Спортын ба уран сайхны гимнастикийн хэрэглэлүүдийг таньдаг.
		6.2.2.2. Дээстэй үсрэлтийг зөв гүйцэтгэдэг.
		6.2.2.3. Гимнастикийн морь, ямаан дээгүүр техникийн дагуу харайж харуулдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.2.1.1. Аюулгүй орчин бүрдүүлж, гар дээр зогсолт, хосоор өнхрөлт зэрэг акробатикийн дасгалыг техникийн дагуу гүйцэтгэдэг.	Хоорондын зайгаа тохируулалгүй, хосоор урагш өнхрөлт ба гар дээр зогсолтын техникийг олон алдаатай гүйцэтгэдэг.	Хоорондын зайгаа тохируулан, хосоор урагш өнхрөлт ба гар дээр зогсолтын техникийг 1-2 том алдаатай гүйцэтгэдэг.	Хоорондын зайгаа тохируулан, хосоор урагш өнхрөлт ба гар дээр зогсолтын техникийг 1-2 жижиг алдаатай гүйцэтгэдэг.	Хоорондын зайгаа тохируулан, хосоор урагш өнхрөлт, гар дээр зогсолтыг техникийн дагуу маш зөв гүйцэтгэдэг.

6.2.1.2. Акробатикийн 4 дасгалыг чөлөөт хөдөлгөөнтэй хослуулсан эвлүүлгийг гүйцэтгэдэг.	Акробатикийн 4 дасгалыг чөлөөт хөдөлгөөнтэй уялдуулахдаа зогсолт хийн, 4-өөс олон алдаатай гүйцэтгэдэг.	Акробатикийн 4 дасгалыг чөлөөт хөдөлгөөнтэй уялдуулан, 3-4 жижиг алдаатай боловч дарааллын дагуу гүйцэтгэдэг.	Акробатикийн 4 дасгалыг чөлөөт хөдөлгөөнтэй уялдуулан, 1-2 жижиг алдаатай боловч дарааллын дагуу чөлөөтэй гүйцэтгэдэг.	Акробатикийн 4 дасгалыг чөлөөт хөдөлгөөнтэй уялдуулан дарааллын дагуу маш зөв, чөлөөтэй гүйцэтгэдэг.
6.2.2.1. Спортын ба уран сайхны гимнастикийн хэрэглэлүүдийг таньдаг.	Спортын ба уран сайхны гимнастикийн бүх хэрэглэлийн зургийг хараад 1-2 хэрэглэлийн нэрийг хэлдэг.	Спортын ба уран сайхны гимнастикийн бүх хэрэглэлийн зургийг хараад цөөн хэрэглэлийн нэрийг хэлдэг.	Спортын ба уран сайхны гимнастикийн бүх хэрэглэлийн зургийг хараад ихэнх хэрэглэлийн нэрийг хэлдэг.	Спортын ба уран сайхны гимнастикийн бүх хэрэглэлийн зургийг хараад: - хэрэглэл бүрийн нэр - эрэгтэй ба эмэгтэй тамирчдын алины төрөл болох зэргийг бүрэн хэлдэг.
6.2.2.2. Дээстэй үсрэлтийг зөв гүйцэтгэдэг.	Дээсийг хоёр гартаа барьж эргүүлээд зөвхөн нэг хэлбэрийн үсрэлтийг гүйцэтгэдэг.	Дээсийг хоёр гартаа барьж эргүүлээд 2 хэлбэрийн үсрэлтийг гүйцэтгэдэг.	Дээсийг хоёр гартаа барьж эргүүлээд 3 хэлбэрийн үсрэлтийг гүйцэтгэдэг.	Дээсийг хоёр гартаа барьж эргүүлээд 4-өөс цөөнгүй хэлбэрийн үсрэлтийг гүйцэтгэдэг.
6.2.2.3. Гимнастикийн морь, ямаан дээгүүр техникийн дагуу харайж харуулдаг.	Охид гимнастикийн ямаан дээгүүр, хөвгүүд морин дээгүүр багшийн дэмжлэгээр хөл салгаж харайхыг оролддог.	Охид гимнастикийн ямаан дээгүүр, хөвгүүд морин дээгүүр хөл салгаж харайх техникээр багшийн дэмжлэгээр харайж харуулдаг.	Охид гимнастикийн ямаан дээгүүр, хөвгүүд морин дээгүүр хөл салгаж харайх техникээр цөөн алдаатай харайж харуулдаг.	Охид гимнастикийн ямаан дээгүүр, хөвгүүд морин дээгүүр хөл салгаж харайх техникээр чөлөөтэй харайж харуулдаг.

1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
3	6.3.1. Сурагч гүйлтийн техникээ ашиглан 60 м зайд дээд хурдаар, 1000-1200 м зайд жигд гүйх ба буухиалан гүйж идэвхтэй тоглодог болно.	6.3.1.1 Гүйлтийн техникээ ашиглан босоо гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйдэг.
		6.3.1.2. Босоо гараанаас 1000-1200 м зайд жигд гүйдэг.
		6.3.1.3. Буухиалан гүйж тоглохдоо гүйлтийн ба дамжуулалтын техникийг ашиглан, өөрийгөө дайчилж өрсөлдөгчөө ялахыг хичээдэг.
	6.3.2. Сурагч уртад “хөл нугалж” харайх техник задлалын хэсгүүдийг нэрлэж, гүйцэтгэх дарааллыг хэлэн, 10-12 м урьдчилсан гүйлтээс уртад уг техникээр харайна.	6.3.2.1. Уртад “хөл нугалж” харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу хэлж, 10-12 м урьдчилсан гүйлтээс уртад уг техникээр харайдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.3.1.1 Гүйлтийн техникээ ашиглан босоо гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйдэг.	Босоо гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 60-70%-иар гүйдэг.	Босоо гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 70-80%-иар гүйдэг.	Босоо гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 80%-иас доошгүй хурдтай гүйдэг.	Босоо гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 90-иас дээш хурдтай гүйдэг.
6.3.1.2. Босоо гараанаас 1000-1200 м зайд жигд гүйдэг.	Охид 1000 м, хөвгүүд 1200 м зайг туулахдаа нийт зайн 50%-ийг алхаж, үлдсэн зайд гүйдэг.	Охид 1000 м, хөвгүүд 1200 м зайг туулахдаа нийт зайн 30-40%-ийг алхаж, үлдсэн зайд гүйдэг.	Охид 1000 м, хөвгүүд 1200 м зайг жигд бус хурдаар гүйж туулдаг.	Охид 1000 м, хөвгүүд 1200 м зайг бүгдийг нь жигд хурдаар гүйж туулдаг.
6.3.1.3. Буухиалан гүйж тоглохдоо гүйлтийн ба дамжуулалтын техникийг ашиглан, өөрийгөө дайчилж өрсөлдөгчөө ялахыг хичээдэг.	Буухианы модыг доороос дамжуулахад эргэж харан, буухиалан тоглохдоо 6-аас хойш байр эзэлдэг.	Буухианы модыг доороос дамжуулахдаа хурдаа сааруулж, буухиалан тоглохдоо 5-6-р байр эзэлдэг.	Хурдтай гүйлтээс доороос дамжуулахдаа хурдаа сааруулж, буухиалан тоглохдоо 3-4-р байр эзэлдэг.	Хурдтай гүйлтээс буухианы модыг доороос дамжуулан, буухиалан тоглохдоо 1-2-р байр эзэлдэг.
6.3.2.1. Уртад “хөл нугалж” харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу хэлж, 10-12 м урьдчилсан гүйлтээс уртад уг техникээр харайдаг.	Гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг бүрэн нэрлэхгүй, 10-12 м зайнаас хурд багатай гүйж, нэг хөлөөр түлхэн, агаарт “хөл нугалах” байдал үзүүлээгүй хөлөө зэрэгцүүлэхгүй буудаг.	Гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийн дарааллыг алдагдуулан нэрлэж, 10-12 м зайнаас дунд зэргийн хурдтай гүйн нэг хөлөөр түлхэн, агаарт “хөл нугалах” байдал үзүүлэхгүй, хоёр хөл дээр буудаг.	Гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэн, 10-12 м зайнаас хурдтай гүйж нэг хөлөөр түлхэн, агаарт “хөл нугалах” оролдлого хийж, хоёр хөлөө зэрэгцүүлэн буудаг.	Гүйлтээс уртад харайх техник задлалын хэсгүүдийг дарааллын дагуу зөв нэрлэн, 10-12 м зайнаас хурдтай гүйж нэг хөлөөр түлхэн, агаарт “хөл нугалах” байдал үзүүлэн, хоёр хөлөө зэрэгцүүлэн буудаг.

1.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
4	6.4.1. Сурагч сагсан бөмбөгийн үндсэн зогсолт, шилжилт, залалтын техникийг гүйцэтгэн, өндөр бай руу шидэж тоглохдоо дүрмийг биелүүлнэ.	6.4.1.1. Үндсэн зогсолт, шилжилт, залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг зөв гүйцэтгэдэг.
		6.4.1.2. 2 м өндөрт байрлуулсан бай руу сагсан бөмбөг шидэж тоглохдоо дүрмийг баримтлан, оновчтой шиддэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.4.1.1. Үндсэн зогсолт, шилжилт, залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг зөв гүйцэтгэдэг.	Үндсэн зогсолт, шилжилт, залалт, дамжуулалт, шидэх техник тус бүрийг 2-оос олон алдаатай гүйцэтгэдэг.	Үндсэн зогсолт, шилжилт, залалт, дамжуулалт, шидэх техник тус бүрийг 1-2 алдаатай гүйцэтгэдэг.	Үндсэн зогсолт, шилжилт, залалт, дамжуулалт, шидэх техник тус бүрийг ерөнхийд нь зөв гүйцэтгэдэг.	Үндсэн зогсолт, шилжилт, залалт, дамжуулалт, шидэх техник тус бүрийг маш зөв, оновчтой гүйцэтгэдэг.
6.4.1.2. 2 м өндөрт байрлуулсан бай руу сагсан бөмбөг шидэж тоглохдоо дүрмийг баримтлан, оновчтой шиддэг.	2 м өндөрт байрлуулсан бай руу сагсан бөмбөг шидэж тоглохдоо дүрмийг баримтлан, 30%-иас доош оновчтой шиддэг.	2 м өндөрт байрлуулсан бай руу сагсан бөмбөг шидэж тоглохдоо дүрмийг баримтлан, 30-40% оновчтой шиддэг.	2 м өндөрт байрлуулсан бай руу сагсан бөмбөг шидэж тоглохдоо дүрмийг баримтлан, 40-50% оновчтой шиддэг.	2 м өндөрт байрлуулсан бай руу сагсан бөмбөг шидэж тоглохдоо дүрмийг баримтлан, 50%-иас дээш оновчтой шиддэг.

1.2.5. Үнэлгээний нэгж 5. Хөл бөмбөг

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
5	6.5.1. Сурагч хөл бөмбөгийн өшиглөх, тогтоох, залах, барих техникийг гүйцэтгэн, тоглохдоо хэрэглэнэ.	6.5.1.1. Бөмбөгийг өшиглөх, тогтоох, залах, хоёр гараар барих техникийг зөв гүйцэтгэдэг.
		6.5.1.2. Хөл бөмбөг тоглохдоо эзэмшсэн техникээ хэрэглэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.5.1.1. Бөмбөгийг өшиглөх, тогтоох, залах, хоёр гараар барих техникийг зөв гүйцэтгэдэг.	Бөмбөгийг өшиглөх, тогтоох, залах, хоёр гараар барих техник тус бүрийг 2-оос олон алдаатай гүйцэтгэдэг.	Бөмбөгийг өшиглөх, тогтоох, залах, хоёр гараар барих техник тус бүрийг 1-2 алдаатай гүйцэтгэдэг.	Бөмбөгийг өшиглөх, тогтоох, залах, хоёр гараар барих техник тус бүрийг ерөнхийд нь зөв гүйцэтгэдэг.	Бөмбөгийг өшиглөх, тогтоох, залах, хоёр гараар барих техник тус бүрийг маш зөв, оновчтой гүйцэтгэдэг.
6.5.1.2. Хөл бөмбөг тоглохдоо эзэмшсэн техникээ хэрэглэдэг.	Хөл бөмбөг тоглохдоо эзэмшсэн техникээ хэрэглэхийг оролддог.	Хөл бөмбөг тоглохдоо эзэмшсэн техникээс цөөнхийг нь үр дүнтэй хэрэглэдэг.	Хөл бөмбөг тоглохдоо эзэмшсэн техникээс ихэнхийг нь оновчтой, үр дүнтэй хэрэглэдэг.	Хөл бөмбөг тоглохдоо эзэмшсэн техник бүрийг оновчтой, маш үр дүнтэй хэрэглэдэг.

1.2.6. Үнэлгээний нэгж 6. Волейбол

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
6	6.6.1. Сурагч волейболын үндсэн зогсолт, шилжилт, дамжуулалтын техникийг зөв гүйцэтгэнэ.	6.6.1.1. Үндсэн зогсолт, шилжилтийг зөв гүйцэтгэж, 2-3 м зайнаас бөмбөгийг доороос ба дээрээс оновчтой дамжуулдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.6.1.1. Үндсэн зогсолт, шилжилтийг зөв гүйцэтгэж, 2-3 м зайнаас бөмбөгийг доороос ба дээрээс оновчтой дамжуулдаг.	Үндсэн зогсолт, шилжилтийн техникийг нэлээд алдаатай гүйцэтгэж, бөмбөгийг доороос ба дээрээс оновчтой дамжуулахыг оролддог.	Үндсэн зогсолт, шилжилтийг бага зэрэг алдаатай гүйцэтгэж, 2 м зайнаас бөмбөгийг доороос ба дээрээс оновчтой дамжуулдаг.	Үндсэн зогсолт, шилжилтийг техникийн дагуу зөв гүйцэтгэж, 2.5 м зайнаас бөмбөгийг доороос ба дээрээс оновчтой дамжуулдаг.	Үндсэн зогсолт, шилжилтийг техникийн дагуу маш зөв гүйцэтгэж, 3 м зайнаас бөмбөгийг доороос ба дээрээс оновчтой дамжуулдаг.

1.2.7. Үнэлгээний нэгж 7. Үндэсний спорт-хурдан морь

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
7	6.7.1. Сурагч хурдан морины уралдааны талаар мэдээлэл цуглуулан хэлэлцэнэ.	6.7.1.1. Хурдан морины цол, уяач, унаач хүүхдийн талаар мэдээлэл цуглуулан, боловсруулж хэлэлцдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
6.7.1.1. Хурдан морины цол, уяач, унаач хүүхдийн талаар мэдээлэл цуглуулан, боловсруулж хэлэлцдэг.	Хурдан морины уралдах зай, цол, уяач, унаач хүүхдийн талаарх цөөн мэдээлэл цуглуулснаа дутуу тайлбарладаг. Асуултад дутуу хариулдаг.	Хурдан морины уралдах зай, цол, уяач, унаач хүүхдийн талаарх цөөн мэдээллийг цуглуулж, ойлгомжтой тайлбарладаг. Цуглуулсан мэдээллийн хүрээний асуултад хариулдаг.	Хурдан морины уралдах зай, цол, уяач, унаач хүүхдийн талаарх мэдээллийн ихэнхийг цуглуулж, ойлгомжтой тайлбарладаг. Цуглуулсан мэдээллийн хүрээний асуултад бүрэн хариулдаг.	Хурдан морины уралдах зай, цол, уяач, унаач хүүхдийн талаарх мэдээллийг бүрэн цуглуулж, ойлгомжтой тайлбарладаг. Асуултад бүрэн хариулдаг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

2.1. VII АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	7.1а. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжих, өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх 7.1б. Бие бялдрын түвшин тогтоох сорилын шалгуураар өөрийн бие бялдрын чийрэгжилтээ хэмжих, ахиц өөрчлөлтөө тодорхойлох, үзүүлэлтээ дээшлүүлэх	7.1. Бие бялдрын хөгжил	7.1.1. Сурагч өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтэд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.
2	7.2а. Өмнөх ангид эзэмшсэн акробатикийн чадвараа нэгтгэж, гар дээр зогсолтоос өнхрөлт, цагариг эргэлтэй холбон гүйцэтгэх 7.2б. Хосоор ачааг зөөхдөө янз бүрийн аргыг ашиглах 7.2в. Цагариг, бөмбөгтэй янз бүрийн дасгалыг гүйцэтгэх	7.2. Гимнастик	7.2.1. Сурагч акробатикийн дасгалуудыг холбон гүйцэтгэнэ.
3	7.3а. Тойрог ба шулуун замд 500-800 м зайд спорт алхаагаар алхаж ерөнхий тэсвэрээ хөгжүүлэх 7.3б. Хол зайд жигд гүйх, дундын зайд давтан гүйх аргыг хэрэглэн, охид 1200 м, хөвгүүд 1500 м зайд алхахгүйгээр гүйж харуулах 7.3в. Нам гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйхдээ сурагч гүйх хугацаагаа тодорхойлон, өөртөө зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх 7.3г. 50 см өндөр халхалтыг даван 25-30 м гүйхдээ халхалттай гүйлтийн техникийг хэрэглэх 7.3д. Уртын харайлтын техникийг зураг дээр тайлбарлах, урьдчилсан гүйлтийн 15-18 м зайнаас гүйж, 20 см өргөн вандангаас түлхэн уртад “хөл нугалж” харайх техникийг гүйцэтгэх	7.3. Хөнгөн атлетик	7.3.1. Сурагч гүйлтийн техникээ ашиглан 1200-1500 м зайд жигд, 60 м зайд дээд хурдаар гүйж харуулна. 7.3.2. Сурагч уртын харайлтын техникийг тайлбарлаж, гүйлтээс “хөл нугалж” харайх техникийг гүйцэтгэнэ.
4	7.4а. Чиглэлээ өөрчлөн бөмбөгийг хурдтай залж гүйх, гүйлтээс дамжуулах, залалтаас зогсолтыг гүйцэтгэх 7.4б. Хоёр алхамтаас бөмбөгийг цагаригт шидэлтийг оновчтой гүйцэтгэх 7.4в. “Мини сагсан бөмбөг”-ийг багаар хамтран тоглохдоо дүрмийг мөрдөж хэрэгжүүлэх	7.4. Сагсан бөмбөг	7.3.1. Сурагч сагсан бөмбөгийг залах, дамжуулах, шидэх техникийг гүйцэтгэн, “Мини сагсан бөмбөг” тоглохдоо дүрмийг хэрэгжүүлнэ
5	7.5а. Бөмбөгийг залж гүйлтээс өшиглөх, цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, хаалгач үсэрч бөмбөгийг хаах техникийг гүйцэтгэх 7.5б. Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг ашиглах 7.5в. Хөлийн хүч, эвслээ хөгжүүлэхдээ бөмбөгийг 1 м өргөн зурвасаар болон аль болох хол өшиглөх дасгал, тоглоомыг ашиглах 7.5г. Жижиг талбайд хөл бөмбөг тоглохдоо футзаалны тэмцээний дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх	7.5. Хөл бөмбөг	7.5.1. Сурагч хөл бөмбөгийн энгийн тактикийг харуулсан зураглалыг ашиглан, бөмбөг дамжуулалт гүйцэтгэнэ. 7.5.2. Сурагч хөл бөмбөгийн цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, хаалгач үсэрч хаах техникийг гүйцэтгэнэ.

6	7.6а. Волейболын бөмбөгийг 5-6 м зайнаас тор давуулахдаа доороос давуулах техникээр гүйцэтгэх 7.6б. Тор давж ирсэн бөмбөгийг хүлээн авахдаа үндсэн зогсолт, шилжилт, дамжуулалтын техникийг ашиглах	7.6. Волейбол	7.6.1. Доороос давуулах ба тор давж ирсэн бөмбөгийг хүлээн авах техникийг гүйцэтгэнэ.
7	7.7а. Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайг тайлбарлах 7.7б. Сур харвааны цол, харваачдын талаар мэдээлэл цуглуулан боловсруулах, хэлэлцэх	7.7. Үндэсний спорт- сур харваа	7.7.1. Сурагч сур харвааны талаар цуглуулсан мэдээллээ тайлбарлаж, хэлэлцэнэ.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

2.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	7.1.1. Сурагч өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтэд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.	7.1.1.1. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжин тодорхойлж, гарсан өөрчлөлтийг тооцоолон, өөрийгөө үнэлдэг. 7.1.1.2. Бие бялдрын чийрэгжилтийг тодорхойлох дасгалуудыг гүйцэтгэж, үр дүнд нь үндэслэн өөрийгөө үнэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.1.1.1. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжин тодорхойлж, гарсан өөрчлөлтийг тооцоолон, өөрийгөө үнэлдэг.	Өөрийн биеийн өндөр, жин болон толгойн, цээжний, бүсэлхийн тойргийг бусдаар хэмжүүлдэг. Эдгээр үзүүлэлтийн өөрчлөлтийг нэлээд алдаатай тооцоолж, өөрийн бие бялдрын хөгжлийг оновчтой бус үнэлдэг.	Бусадтай хамтран өөрийн биеийн өндөр, жин болон толгойн, цээжний, бүсэлхийн тойргийг хэмжихдээ их туслалцаа авдаг. Эдгээр үзүүлэлтийн өөрчлөлтийг цөөн алдаатай тооцоолж, өөрийн бие бялдрын хөгжлийг оновчтой бус үнэлдэг.	Бусадтай хамтран өөрийн биеийн өндөр, жин болон толгойн, цээжний, бүсэлхийн тойргийг хэмжихдээ бага зэргийн дэмжлэг авдаг. Эдгээр үзүүлэлтийн өөрчлөлтийг бүгдийг зөв тооцоолж, өөрийн бие бялдрын хөгжлийг үнэлдэг.	Бусадтай хамтран өөрийн биеийн өндөр, жин болон толгойн, цээжний, бүсэлхийн тойргийг зөв хэмжиж, эдгээр үзүүлэлтийн өөрчлөлтийг бүгдийг зөв тооцоолж, өөрийн бие бялдрын хөгжлийг оновчтой үнэлдэг.
7.1.1.2. Бие бялдрын чийрэгжилтийг тодорхойлох дасгалуудыг гүйцэтгэж, үр дүнд нь үндэслэн өөрийгөө үнэлдэг.	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын дасгалуудын заримыг дунд ба доогуур түвшинд гүйцэтгэдэг. Өөрийн чийрэгжилтийг алдаатай үнэлдэг.	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын дасгалуудын заримыг хангалттай ба дунд түвшинд гүйцэтгэдэг. Өөрийн чийрэгжилтийг алдаатай үнэлдэг.	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын бүх дасгалыг хангалттай түвшинд гүйцэтгэдэг. Өөрийн чийрэгжилтийг зөв үнэлдэг.	"Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын бүх дасгалыг хангалттай сайн түвшинд гүйцэтгэдэг. Өөрийн чийрэгжилтийг үндэслэлтэй, зөв үнэлдэг.

2.2.2. Үнэлгээний нэгж 2. Гимнастик

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
2	7.2.1. Сурагч акробатикийн дасгалуудыг холбон гүйцэтгэнэ.	7.2.1.1. Гар дээр зогсолт, өнхрөлт, цагариг эргэлтийг акробатикийн бусад дасгалтай холбон, техникийн дагуу гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.2.1.1. Гар дээр зогсолт, өнхрөлт, цагариг эргэлтийг акробатикийн бусад дасгалтай холбон, техникийн дагуу гүйцэтгэдэг.	Гар дээр зогсолтоос өнхрөлт, цагариг эргэлт, акробатикийн бусад дасгалын заримыг огт гүйцэтгэж чадахгүй, холбоосыг чөлөөтэй бус гүйцэтгэдэг.	Гар дээр зогсолтоос өнхрөлт, цагариг эргэлт, акробатикийн бусад дасгалыг нэлээд алдаатай, холбоосыг чөлөөтэй бус гүйцэтгэдэг.	Гар дээр зогсолтоос өнхрөлт, цагариг эргэлт, акробатикийн бусад дасгалыг техникийн цөөн алдаатай, холбоосыг чөлөөтэй гүйцэтгэдэг.	Гар дээр зогсолтоос өнхрөлт, цагариг эргэлт, акробатикийн бусад дасгалыг техникийн дагуу маш зөв бөгөөд холбоосыг чөлөөтэй гүйцэтгэдэг.

2.2.3. үнэлгээний нэгж 3. Хөнгөн атлетик

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
3	7.3.1. Сурагч гүйлтийн техникээ ашиглан 1200-1500 м зайд жигд, 60 м зайд дээд хурдаар гүйж харуулна.	7.3.1.1. Босоо гараанаас охид 1200 м, хөвгүүд 1500 м зайд жигд гүйдэг.
		7.3.1.2. Гүйлтийн техникээ ашиглан, нам гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйдэг.
	7.3.2. Сурагч уртын харайлтын техникийг тайлбарлаж, гүйлтээс “хөл нугалж” харайх техникийг гүйцэтгэнэ.	7.3.2.1. Уртад “хөл нугалж” харайх техникийг зураг дээр тайлбарладаг.
		7.3.2.2. Гүйлтээс уртад харайхдаа “хөл нугалах” техникийг гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.3.1.1. Босоо гараанаас охид 1200 м, хөвгүүд 1500 м зайд жигд гүйдэг.	Охид 1200 м, хөвгүүд 1500 м зайг туулахдаа нийт зайн 50%-ийг алхаж, үлдсэн зайд гүйдэг.	Охид 1200 м, хөвгүүд 1500 м зайг туулахдаа нийт зайн 30-40%-ийг алхаж, үлдсэн зайд гүйдэг.	Охид 1200 м, хөвгүүд 1500 м зайг жигд бус хурдаар гүйж туулдаг.	Охид 1200 м, хөвгүүд 1500 м зайг бүгдийг нь жигд хурдаар гүйж туулдаг.
7.3.1.2. Гүйлтийн техникээ ашиглан, нам гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйдэг.	Нам гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 50-60%-иар гүйдэг.	Нам гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 60-70%-иар гүйдэг.	Нам гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 70-80%-иас доошгүй хурдтай гүйдэг.	Нам гараанаас 60 м зайд өөрийн дээд хурдны 90%-иас дээш хурдтай гүйдэг.

7.3.2.1. Уртад “хөл нугалж” харайх техникийг зураг дээр тайлбарладаг.	Зураг дээрх уртад “хөл нугалж” харайх техникийн үйлдлүүдийг дарааллаар нь нэрлэсэн боловч биеийн тамирын нэр томьёог зөв хэрэглээгүй, дутуу тайлбарладаг.	Зураг дээрх уртад “хөл нугалж” харайх техникийн үйлдлүүдийг дарааллаар нь нэрлэж, биеийн тамирын хэлээр бүрэн бус тайлбарладаг.	Зураг дээрх уртад “хөл нугалж” харайх техникийн үйлдлүүдийг дарааллаар нь бүрэн, биеийн тамирын хэлээр нэлээд товчхон тайлбарладаг.	Зураг дээрх уртад “хөл нугалж” харайх техникийн үйлдлүүдийг дарааллаар нь бүрэн, биеийн тамирын хэлээр ойлгомжтой, дэлгэрэнгүй тайлбарладаг.
7.3.2.2. Гүйлтээс уртад харайхдаа “хөл нугалах” техникийг гүйцэтгэдэг.	15-18 м зайнаас бага хурдтай гүйж, 20 см өргөн вандангаас нэг хөлөөр түлхэн, агаарт хөл нугалах оролдлого хийлгүй, хоёр хөлөө цувруулан буудаг.	15-18 м зайнаас дунд зэргийн хурдтай гүйж, 20 см өргөн вандангаас нэг хөлөөр түлхэн, агаарт хөл нугалах оролдлого хийгээд, хөлөө зэрэгцүүлэн, уртад харайж буудаг.	15-18 м зайнаас хурдтай гүйж, 20 см өргөн вандангаас нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт хөл нугалах оролдлого хийгээд, хөлөө зэрэгцүүлэн, аль болох хол харайж буухыг хичээдэг.	15-18 м зайнаас их хурдтай гүйж, 20 см өргөн вандангаас нэг хөлөөр хүчтэй түлхэн, агаарт хөл нугалах байдлыг тодорхой үзүүлээд, хөлөө зэрэгцүүлэн, аль болох хол харайж буудаг.

2.2.4. Үнэлгээний нэгж 4. Сагсан бөмбөг

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
4	7.3.1. Сурагч сагсан бөмбөгийг залах, дамжуулах, шидэх техникийг гүйцэтгэн, “Мини сагсан бөмбөг” тоглохдоо дүрмийг хэрэгжүүлнэ	7.3.1.1. Дамжуулсан бөмбөгийг хүлээн авч, залалтаас хоёр алхамт хийж, цагаригт шидэлтийг оновчтой гүйцэтгэдэг.
		7.3.1.2. “Мини сагсан бөмбөг”-ийг багаар хамтран тоглохдоо дүрмийг хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.3.1.1. Дамжуулсан бөмбөгийг хүлээн авч, залалтаас хоёр алхамт хийж, цагаригт шидэлтийг оновчтой гүйцэтгэдэг.	Бөмбөг дамжуулалт, залалт, хоёр алхамтаас шидэлт хосолсон дасгалыг удаавтар хөдөлгөөнөөр, оновчтой бус гүйцэтгэдэг.	Бөмбөг дамжуулалт, залалт, хоёр алхамтаас шидэлт хосолсон дасгалыг дунд зэргийн хурдтай, оновчтой бус гүйцэтгэдэг.	Бөмбөг дамжуулалт, залалт, хоёр алхамтаас шидэлт хосолсон дасгалыг дунд зэргийн хурдтай, зөв, ихэнхийг нь оновчтой гүйцэтгэдэг.	Бөмбөг дамжуулалт, залалт, хоёр алхамтаас шидэлт хосолсон дасгалыг чөлөөтэй, хурдтай, зөв, оновчтой гүйцэтгэдэг.
7.3.1.2. “Мини сагсан бөмбөг”-ийг багаар хамтран тоглохдоо дүрмийг хэрэгжүүлдэг.	“Мини сагсан бөмбөг” тоглохдоо дүрмийг хэрэгжүүлэхийг оролддог.	“Мини сагсан бөмбөг” тоглохдоо дүрмийг сануулга, анхааруулгатай хэрэгжүүлдэг.	“Мини сагсан бөмбөг” тоглохдоо ихэнх дүрмийг үр дүнтэй хэрэгжүүлдэг.	“Мини сагсан бөмбөг” тоглохдоо дүрмийг бүгдийг нь маш сайн, үр дүнтэй хэрэгжүүлдэг.

2.2.5. Үнэлгээний нэгж 5. Хөл бөмбөг

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
5	7.5.1. Сурагч хөл бөмбөгийн энгийн тактикийг харуулсан зураглалыг ашиглан, бөмбөг дамжуулалт гүйцэтгэнэ.	7.5.1.1. Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг багаараа тайлбарлан, зургийн дагуу гүйцэтгэж харуулдаг.
	7.5.2. Сурагч хөл бөмбөгийн өшиглөх, цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, хаалгач үсэрч хаах техникийг гүйцэтгэнэ.	7.5.2.1. Бөмбөгийг цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, залж гүйлтээс хаалга руу өшиглөх, хаалгач үсэрч хаах техникийг нэгтгэсэн даалгаврыг гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.5.1.1. Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг багаараа тайлбарлан, зургийн дагуу гүйцэтгэж харуулдаг.	Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг тайлбарлаж чадхгүй, зургийн дагуу багаараа үйлдлийг гүйцэтгэхийг оролддог.	Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг ярилцаж, зургийн дагуу багаараа бусдын дэмжлэгтэйгээр гүйцэтгэдэг.	Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг оновчтой тайлбарлаж, зургийн дагуу багаараа ихэнх үйлдлийг зөв гүйцэтгэдэг.	Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг оновчтой тайлбарлаж, зургийн дагуу багаараа зөв гүйцэтгэдэг.
7.5.2.1. Бөмбөгийг цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, залж гүйлтээс хаалга руу өшиглөх, хаалгач үсэрч хаах техникийг нэгтгэсэн даалгаврыг гүйцэтгэдэг.	Бөмбөгийг цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, залж гүйлтээс хаалга руу өшиглөх, хаалгач үсэрч хаах техникийг нэгтгэсэн даалгаврыг нэлээд их алдаатай, удаавтар хөдөлгөөнөөр, зогсолттой гүйцэтгэдэг.	Бөмбөгийг цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, залж гүйлтээс хаалга руу өшиглөх, хаалгач үсэрч хаах техникийг нэгтгэсэн даалгаврыг удаавтар хөдөлгөөнөөр, зогсолттой гүйцэтгэдэг.	Бөмбөгийг цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, залж гүйлтээс хаалга руу өшиглөх, хаалгач үсэрч хаах техникийг нэгтгэсэн даалгаврыг зөв, дунд зэргийн хурдтай, оновчтой гүйцэтгэдэг.	Бөмбөгийг цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, залж гүйлтээс хаалга руу өшиглөх, хаалгач үсэрч хаах техникийг нэгтгэсэн даалгаврыг зөв, хурдтай, оновчтой гүйцэтгэдэг.

2.2.6. Үнэлгээний нэгж 6. Волейбол

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
6	7.6.1. Доороос давуулах ба тор давж ирсэн бөмбөгийг хүлээн авах техникийг гүйцэтгэнэ.	7.6.1.1. Бөмбөгийг доороос давуулах ба тор давж ирсэн бөмбөгийг хүлээн авахдаа үндсэн зогсолт, шилжилт, дамжуулалтын техникүүдийг ашигладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.6.1.1. Бөмбөгийг доороос давуулах ба тор давж ирсэн бөмбөгийг хүлээн авахдаа үндсэн зогсолт, шилжилт, дамжуулалтын техникүүдийг ашигладаг.	Бөмбөгийг доороос давуулах техникээр бөмбөгийг тор давуулахыг оролдсон. Давуулалтын бөмбөгийг хүлээн авсан боловч өөрийн багийн тоглогч руу дамжуулж чадаагүй.	Бөмбөгийг доороос давуулах техникээр цөөн бөмбөгийг тор давуулсан. Давуулалтын бөмбөгийг хүлээн авч өөрийн багийн тоглогч руу дамжуулахыг оролдсон.	Бөмбөгийг доороос давуулах техникийг зөв гүйцэтгэж, ихэнх бөмбөг тор давсан. Давуулалтын бөмбөгийг зөв техникээр хүлээн авч өөрийн багийн тоглогч руу ойртуулж дамжуулсан.	Бөмбөгийг доороос давуулах техникийг зөв гүйцэтгэж, бөмбөг бүр нь тор давсан. Давуулалтын бөмбөгийг зөв техникээр хүлээн авч өөрийн багийн тоглогч руу оновчтой дамжуулсан.

2.2.7. үнэлгээний нэгж 7. Үндэсний спорт-сур харваа

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
7	7.7.1. Сурагч сур харвааны талаар цуглуулсан мэдээллээ тайлбарлаж, хэлэлцэнэ.	7.7.1.1. Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайн талаар мэдээлэл цуглуулан, тайлбарлаж, хэлэлцдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
7.7.1.1. Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайн талаар мэдээлэл цуглуулан, тайлбарлаж, хэлэлцдэг.	Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайны талаарх мэдээллийн заримыг цуглуулсан боловч ойлгомжтой бус тайлбарладаг, асуултад бүрэн бус хариулдаг.	Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайны талаарх мэдээллийн заримыг цуглуулж, ойлгомжтой тайлбарладаг, асуултад бүрэн бус хариулдаг.	Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайны талаарх мэдээллийг бүрэн цуглуулж, ойлгомжтой тайлбарладаг, асуултад бүрэн бус хариулдаг.	Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайны талаарх мэдээллийг бүрэн цуглуулж, ойлгомжтой тайлбарладаг, асуулт асуух ба асуултад зөв хариулдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

3.1. VIII АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	8.1а. Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг тайлбарлах, зөвлөгөө өгөх, биеэ чийрэгжүүлэхдээ ашиглах 8.1б. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжиж, өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх 8.1в. Бие бялдрын түвшин тогтоох сорилын шалгуураар өөрийн бие бялдрын чийрэгжилтээ хэмжих, ахиц өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх 8.1г. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтээ дээшлүүлэх дасгалыг сонгох, ачааллаа өөртөө тохируулан гүйцэтгэх	8.1. Бие бялдрын хөгжил	8.1.1. Сурагч нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг бусдад зөвлөнө
			8.1.2. Сурагч өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтэд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.
2	8.2а. Аэробикийн үндсэн 7 алхалтыг хөгжмийн аянд гүйцэтгэх 8.2б. Аэробикийн үндсэн алхалтыг гарын ба бусад хөдөлгөөнтэй хослуулсан зохиомжит дасгалыг хөгжмийн аянд гүйцэтгэх	8.2. Аэробик	8.2.1. Сурагч аэробикийн үндсэн 7 алхалтыг гарын хөдөлгөөнтэй хослуулан, хөгжмийн аянд гүйцэтгэнэ.
3	8.3а. Бүжгийн ангиллыг тайлбарлах, биелгээний үндсэн зогсолт, их бие, хөл, гарын энгийн хөдөлгөөнтэй танилцаж ахуйн зан үйлийг хөгжмийн аянд биелж харуулах 8.3б Их бие, хөл, гарын энгийн хөдөлгөөнтэй хип хоп бүжгийг хөгжмийн аянд дэглэн гүйцэтгэх	8.3. Бүжиг	8.3.1. Бүжгийн ангиллыг тайлбарлан, үндсэн зогсолт, их бие, хөл гарын энгийн хөдөлгөөнтэй ахуйн зан үйлийн биелгээг хөгжмийн аянд харуулдаг.
4	8.4а. Шулуун ба тойрог замд спортын алхаагаар 800-1000 м зайд уралдаж алхах, 2000 м зайг гүйж туулахдаа жигд гүйх ба давтан гүйлтийн аргуудыг ашиглах 8.4б. Нам гараанаас 60-80 м хүртэл янз бүрийн зайд дээд хурдтай гүйж хурдаа хөгжүүлэх 8.4в. 4х60 м буухиад уралдаж гүйхдээ буухианы модыг доороос дамжуулах техникийг ашиглах 8.4г. Бүтэн гүйлтээс өндөрт “алхаж” харайх техникийг гүйцэтгэхдээ техник задлалын хэсгүүдийг тодорхойлох, аюулгүйн дүрмийг хэрэгжүүлэх, хөлийн түлхэлтийн хүчийг хөгжүүлэх 8.4д. Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцож, 150 г жинтэй жижиг бөмбөгийг хол шидэж харуулах 8.4е. 400-500 г жинтэй хүүхдийн жадыг байрнаас шидэх техникийг гүйцэтгэх	8.4. Хөнгөн атлетик	8.4.1. Сурагч 4х60 м буухиалан гүйж ба 800-1000 м зайд спорт алхаагаар уралдан алхаж харуулна.
			8.4.2. Сурагч өндөрт “алхаж” харайх техник задлалын хэсгүүдийг тодорхойлон, бүтэн гүйлтээс өндөрт уг техникээр харайж харуулна.
			8.4.3. Сурагч 150 г жинтэй жижиг бөмбөгийг хол шидэж харуулна.

5	8.5а. 3х3 сагсан бөмбөг тоглохдоо залалт, дамжуулалт, шидэлтийн техникээ ашиглах 8.5б. 3х3 сагсан бөмбөгийн тоглолтын дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх	8.5. Сагсан бөмбөг	8.5.1. Сурагч 3х3 сагсан бөмбөг тоглохдоо залалт, дамжуулалт, шидэлтийн техникийг гүйцэтгэн, тоглолтын дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлнэ.
6	8.6а. Мини волейбол тоглохдоо дамжуулалт, доороос давуулалтын техникээ ашиглах 8.6б. Мини волейбол тоглохдоо дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх	8.6. Волейбол	8.6.1. Сурагч Мини волейбол тоглохдоо дамжуулалт, доороос давуулалтын техникээ гүйцэтгэн, тоглолтын дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлнэ.
7	8.7а. Үндэсний бөхийн гараа, дэвээ, шаваа, тахим авах, өгөх ёсны утга агуулгыг тайлбарлах 8.7б. Үндэсний бөхийн барилдааны засуулын үүргийг тодорхойлох, бөхчүүдийн цолны ялгааг таних 8.7в. Үндэсний бөхийн суйлах, хавирах, этэх мэхийг таних, гүйцэтгэх	8.7. Үндэсний спорт-Бөхийн барилдаан	8.7.1. Сурагч үндэсний бөхийн ёс жаяг, бөхчүүдийн цолны ялгааг таньж, тайлбарлана.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

3.2.1. Үнэлгээний нэгж 1. Бие бялдрын хөгжил

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1.	8.1.1. Сурагч нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг бусдад зөвлөнө.	8.1.1.1. Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг тайлбарлан, зөвлөгөө өгдөг.
	8.2.1. Сурагч өөрийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн үзүүлэлтэд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлж, үнэлнэ.	8.2.1.1. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцоолдог.
		8.2.1.2. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 13-14 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан, бие бялдрын хөгжилдөө үнэлгээ өгдөг.
		8.2.1.3. “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын дасгалуудыг гүйцэтгэж, өөрийн насанд тохирох нормыг биелүүлдэг.
		8.2.1.4. Өөрийн бие бялдрын чийрэгжилтэд үндэслэлтэй үнэлгээ өгч танилцуулдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
8.1.1.1. Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг тайлбарлан, зөвлөгөө өгдөг.	Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг тайлбарлахыг оролддог.	Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг дутуу тайлбарлан, зөвлөгөө өгөхийг оролддог.	Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг ерөнхийд нь тайлбарлан, ойлгомжтой зөвлөгөө өгдөг.	Нараар биеэ чийрэгжүүлэх аргачлалыг бүрэн, оновчтой тайлбарлан, ойлгомжтой зөвлөгөө өгдөг.
8.2.1.1. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тооцоолдог.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтээ мэдсэн боловч гарсан өөрчлөлтийг тооцоолж чадаагүй.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойрог зэргээс 1-2 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг зөв тооцоолдог.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойрог зэргээс 3 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг зөв тооцоолдог.	Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойрог зэрэг 4 үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг бүгдийг бүрэн зөв тооцоолдог.
8.2.1.2. Өөрийн биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 13-14 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан, бие бялдрын хөгжилдөө үнэлгээ өгдөг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 13-14 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан оновчтой биш үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ буруу танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 13-14 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан оновчтой биш үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ дутуу танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 13-14 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан зөв үнэлсэн боловч үнэлгээний үндэслэлээ ерөнхий байдлаар танилцуулдаг.	Биеийн өндөр, жин, цээжний ба бүсэлхийн тойргийн үзүүлэлтийг 13-14 насны монгол хүүхдийн дундаж үзүүлэлттэй харьцуулан өөрийн үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ тодорхой, ойлгомжтой танилцуулдаг.
8.2.1.3. “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын дасгалуудыг гүйцэтгэж, өөрийн насанд тохирох нормыг биелүүлдэг.	Сорилын дасгалуудын заримыг дунд ба доогуур түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 60-70 хувьтай хангадаг.	Сорилын дасгалуудын заримыг хангалттай ба дунд түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 71-80 хувьтай хангадаг.	Сорилын бүх дасгалыг хангалттай түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 81-90 хувьтай хангадаг.	Сорилын бүх дасгалыг хангалттай сайн түвшинд гүйцэтгэж, ерөнхий үнэлгээний болзлыг 91-ээс дээш хувьтай хангадаг.
8.2.1.4. Өөрийн бие бялдрын чийрэгжилтэд үндэслэлтэй үнэлгээ өгч танилцуулдаг.	Сорилын зарим дасгалын шалгуурын дагуу өөртөө алдаатай үнэлгээ өгч, үнэлгээний үндэслэлээ буруу танилцуулдаг.	Сорилын зарим дасгалын шалгуурын дагуу өөрийгөө үнэлэн, үнэлгээний үндэслэлээ дутуу танилцуулдаг.	Сорилын бүх дасгалын шалгуурын дагуу өөрийгөө зөв үнэлэн, үнэлгээний үндэслэлээ ерөнхий байдлаар танилцуулдаг.	Сорилын бүх дасгалын шалгуурын дагуу өөрийгөө зөв үнэлэн, үнэлгээний үндэслэлээ оновчтой, ойлгомжтой танилцуулдаг.

3.2.2. Үнэлгээний нэгж 2. Аэробик

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
2	8.2.1. Сурагч аэробикийн үндсэн 7 алхалтыг гарын хөдөлгөөнтэй хослуулан, хөгжмийн аянд гүйцэтгэнэ.	8.2.1.1. Аэробикийн үндсэн 7 алхалт ба гарын хөдөлгөөн хосолсон цогц дасгалыг хөгжмийн аянд гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
8.2.1.1. Аэробикийн үндсэн 7 алхалт ба гарын хөдөлгөөн хосолсон цогц дасгалыг хөгжмийн аянд гүйцэтгэдэг.	Аэробикийн үндсэн 7 алхалт ба гарын хөдөлгөөн хосолсон цогц дасгалыг багшийн тоололтод тохируулан, чиглүүлэгчийг дуурайн, нэлээд алдаатай гүйцэтгэдэг.	Аэробикийн үндсэн 7 алхалт ба гарын хөдөлгөөн хосолсон цогц дасгалыг хөгжмийн аятай зэрэгцүүлсэн тоололтод тохируулан, чиглүүлэгчийг дуурайн гүйцэтгэдэг.	Аэробикийн үндсэн 7 алхалт ба гарын хөдөлгөөн хосолсон цогц дасгалыг хөгжмийн аянд тохируулан, дарааллын дагуу, бага зэргийн алдаатай, бие даан гүйцэтгэдэг.	Аэробикийн үндсэн 7 алхалт ба гарын хөдөлгөөн хосолсон цогц дасгалыг хөгжмийн аянд тохируулан, дарааллын дагуу, зөв, бие даан чөлөөтэй гүйцэтгэдэг.

3.2.3. Үнэлгээний нэгж 3. Бүжиг

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
3	8.3.1. Бүжгийн ангиллыг тайлбарлан, үндсэн зогсолт, их бие, хөл гарын энгийн хөдөлгөөнтэй ахуйн зан үйлийн биелгээг хөгжмийн аянд харуулдаг.	8.3.1.1. Бүжгийн ангиллыг тайлбарлан, үндсэн зогсолт, их бие, хөл гарын энгийн хөдөлгөөнтэй ахуйн зан үйлийн биелгээг хөгжмийн аянд харуулдаг.
		8.3.1.2. Их бие, хөл, гарын энгийн хөдөлгөөнтэй хип хоп бүжгийг хөгжмийн аянд гүйцэтгэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
